



ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА

**Цар тахал, хөл хорио болон эдийн засгийн суурь
нөхцлүүд бизнесийн орчинд нөлөөлөх нь**

2021

Улаанбаатар хот, Монгол Улс

АГУУЛГА

ХУРААНГУЙ	2
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	7
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЖДБЭ-Н ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА	8
1.1. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДСЭН ЗОРИЛГО	8
1.2. АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ, ЦАГАЛБАР	8
1.3. СУДАЛГААНЫ АЖЛЫН ТҮҮВЭРЛЭЛТ, БИЗНЕСИЙН ОРЧИН-ГАЗАРЗҮЙН ОНЦЛОГУУД.....	9
1.4. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, ЯВЦЫН БОЛОН ЭЦСИЙН ХЯНАЛТ.....	13
1.5. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН.....	14
1.5.1. Санхүү, эдийн засгийн өрсөлдөх чадвар.....	18
1.5.2. Ажиллах хүчний өрсөлдөх чадвар	25
1.5.3. Тоног, төхөөрөмжийн болон антепренер өрсөлдөх чадвар	28
1.5.4. Макро эдийн засгийн өрсөлдөх чадвар	31
1.5.5. Экспортын өрсөлдөх чадвар, саад бэрхшээлүүд.....	33
1.5.6. Дэд бүтцийн салбарын өрсөлдөх чадвар, бэрхшээлүүд.....	35
1.5.7. Жижиг, дунд бизнесийн салбарын хүндрэл, боломжит шийдлүүд.....	37
1.6. НӨХЦӨЛТ СУДАЛГААНЫ НАРИЙВЧИЛСАН ҮР ДҮНГҮҮД	39
1.7. ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ЭРГЭХ ХОЛБОО	46
ХОЁРДУГААР БҮЛЭГ: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	48
2.1. Макро эдийн засгийн нөхцөл байдал	48
2.2. Макро эдийн засгийн цаашидын төлөв	54
ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖҮҮД	57
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	60

ХУРААНГУЙ

Монгол Улс дахь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн (цаашид ЖДБЭ гэх) өрсөлдөх чадварыг үнэлэх, өрсөлдөх чадвараа сайжруулах цаашдын хэрэгцээ шаардлага болон бараа бүтээгдэхүүн экспортлоход тулгардаг саад, бэрхшээлийг илүү сайн тодорхойлж ойлгох нь энэхүү судалгааны үндсэн зорилго байв. Түүнчлэн бүхий л улсын бизнес эрхлэгчдэд ялангуяа жижиг, дунд бизнесийн салбарт учирч буй “Коронавирус-19” цар тахлын сөрөг нөлөөг манай улсын ЖДБЭ-дийн хувьд гүнзгийрүүлэн судлах нь уг судалгааны ажлын удаах зорилго байв.

Түүвэр судалгааны асуулгын анхдагч дизайныг боловсруулж улмаар жижиг, дунд бизнес эрхлэгчдийн эх олонлогийг хамгийн сайн төлөөлөх “дэд” олонлогийг нийгэм, жижиг дунд бизнесийн орчин, онцлогт нь нийцүүлэн боловсруулж улмаар статистикийн “бүлэгчилсэн түүвэр”-ийн аргыг ашиглан судалгаанд оролцогчдыг тодорхойлсон. Эх олонлогийн үндсэн шинж чанаруудыг зохих ёсоор проекцлон буулгасан дэд олонлогийг Монгол Улсын “Бизнес, регистрийн сан”-д бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудаас нөхцөлт санамсаргүй түүврийн аргаар 5000 жижиг, дунд бизнес эрхлэгчдийн ерөнхий мэдээллийг татан авч бүрдүүлэлт хийсэн. Энэхүү дэд олонлогт Улаанбаатар хотын 8 дүүрэг, бүх 21 аймгийг оролцуулаад нийт 1545 ЖДБЭ хамрагдсан бөгөөд үүнээс 1064 судалгааг зайнаас буюу САТI хэлбэрээр, 481 судалгааг биечлэн буюу газар дээр нь САРI хэлбэрээр хийж гүйцэтгэв.

Судалгаанд оролцсон нийт жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 45% нь буюу 695 аж ахуйн нэгж бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт, 11% нь буюу 169 аж ахуйн нэгж боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бол 124 барилгын компани, 73 хөдөө аж ахуйн компани, 36 аялал жуулчлалын компани мөн оролцлоо. Эндээс үзэхэд манай улсын ЖДБЭ-дийн хувьд бараг тэн хагас нь нэмүү өртөг багатай худалдааны салбарт ажилладаг бол экспортын чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг маш цөөхөн компани байдаг байна.

Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг үнэлэхийн тулд олон улсад түгээмэл хэрэглэгддэг аргачлалыг дараах бүтцийн дагуу ашиглав. Үүнд: 1. Санхүү, эдийн засгийн өрсөлдөх чадвар, 2. Ажиллах хүчний өрсөлдөх чадвар, 3. Тоног төхөөрөмжийн хангамж болон антепренер өрсөлдөх чадвар, 4. Макро эдийн засгийн өрсөлдөх чадвар, 5. Экспортын өрсөлдөх чадвар, 6. Дэд бүтцийн өрсөлдөх чадвар.

Судалгааны зарим үр дүнгээс дурдахад, сүүлийн 18 сарын туршид буюу цар тахлын нөлөө улсын эдийн засагт сөргөөр мэдрэгдэж эхэлснээс хойш нийт ЖДБЭ-дийн 76%-ийнх нь борлуулалтын орлого буурсан буюу 4 компани тутмын 3 нь цар тахалд “өртөж” байна. Мөн 2 компани тутмын 1 нь 2020 онд алдагдалтай ажилласан бол 3 компани тутмын 1 нь л ашигтай ажиллажээ. Түүнчлэн нийт ЖДБЭ-дийн 25% нь шинээр санхүүжилт авч, санхүүжилтийн 75% нь банкны зээл байжээ. Судалгаанд хамрагдсан 4 компани тутмын 1 нь барьцаа хөрөнгө дутмагаас болж зээл авч чадаагүй бол 18% нь зээлийн хүү өндөр байдаг гэж хариулсан. Иймд бодлого боловсруулагчдын зүгээс зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг бодитоор дэмжих, зээлийн хүүг шат дараатай бууруулах шаардлагатай байхаас гадна хөрөнгийн үнэлгээний чадавхийг дээшлүүлэх, бодитоор үнэлэх ажлыг эрчимжүүлэх нь чухал болжээ.

Нийт судалгаанд хамрагдагсдын 52% нь цар тахлын үед тулгамдаж буй санхүүгийн хамгийн том хүндрэл бол ажилчдын цалин, НДШ гэж хариулсан бол 48% нь

НӨАТ, ААНОАТ, Гаалийн болон татварын зардал гэж үзэж байна. Монгол Улсын Засгийн газраас тус салбарыг дэмжихээр яг одоо хэрэгжүүлж буй 9 арга хэмжээнээс зөвхөн 1 арга хэмжээ буюу “Тогтмол зардлын төлбөр чөлөөлсөн” шийдвэр ЖДБЭ-дийн 59%-ийн дэмжлэгийг авч чадаж байна. Мөн НДШ-ийн тодорхой хувийг чөлөөлсөн арга хэмжээ бизнес эрхлэгчдийн 30%-д хүрчээ. Харамсалтай нь бусад 7 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрч чадаагүй, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан, тунхаглалын шинжтэй болжээ. Учир нь судалгаанд оролцогчдын дунджаар 75% нь уг 7 арга хэмжээг “нөлөө үзүүлээгүй” гэж хариулжээ.

Ажиллах хүчний өрсөлдөх чадварын хувьд судалгаанд оролцогчдын тал орчим хувь нь шаардлага хангасан боловсон хүчин хөдөлмөрийн зах зээл дээр “боломжийн” байдаг, мөн удирдлагын 94% нь ажилчдынхаа үр чадварыг “маш сайн, сайн болон боломжийн” гэж хариулсан нь ЖДБЭ-дийн хувьд хөдөлмөрийн зах зээл дээр системийн шинжтэй хүндрэл үүсээгүй болохыг нотлож байна. Гэхдээ дотооддоо болон олон улсын түвшинд өрсөлдөх чадвараа сайжруулахын тулд ажилчдыг тогтмол давтан сургах нь чухал бөгөөд судалгаа, хөгжүүлэлтийн ажилд төсөв хөрөнгө зарцуулж шинэ боломжууд эрэлхийлж байх нь чухал. Тус салбарын 4 компани тутмын 3 нь сүүлийн үед дангаараа эсхүл бусадтай хамтран судалгаа, хөгжүүлэлтийн ажил хийгээгүй гэж хариулсан байна. Дүгнэж үзвэл хэдийгээр цар тахлын нөлөө ЖДБЭ-дэд хүчтэй цохилт болж буй нь тодорхой ч манай ЖДБЭ-дийн “антпренер” сэтгэлгээ, чадавхи хангалттай биш байна.

Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаандаа ашиглаж буй тоног төхөөрөмж нь шаарлага хангаж буй гэж 10 оролцогчдын 7 нь хариулсан боловч инноваци хийхэд тоног төхөөрөмжөө шинэчлэх шаардлагатай гэж 5 оролцогчийн 4 нь үзсэн. Иймд жижиг, дунд бизнесийн салбарт технологийн шинэчлэл хийх асуудлыг хэрэгцээ болон хүчин чадалд нь тулгуурлаж гүнзгийрүүлэн судлах шаардлагатай нь харагдаж байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлэхэд дотоодын нөөц, түүхий эдийг 100% ашигладаг хэмээн 5 компани тутмын 1 нь хариулсан бол 10 компани тутмын 6 нь орцынхоо ердөө 50 хүртэлх хувийг дотоодын түүхий эд, нөөцөөр хангадаг байна. Өөрөөр хэлбэл цаашид цар тахал болон аливаа улс төр, эдийн засгийн шалтгаанаар хил хаагдах нөхцөлд нийт жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 80%-д нь үйл ажиллагааны доголдол үүсч түүний 75% нь богино хугацаанд түүхий эд, орцын гачигдалд өртөх эрсдэлтэй байна. Иймд төрийн зүгээс дотоодын аж ахуйн нэгжүүдийн нийлүүлэлтийн гинжин хэлхээг илүү боловсронгуй, үр ашигтай болгох, дотооддоо импортын орц, түүхий эдийг орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх чухал шаардлагатай байна.

Улсын эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал ЖДБЭ-дэд хэрхэн нөлөөлж буй талаар лавлахад оролцогчдын 60% нь муугаар, 30% нь маш муу нөлөөлж байна гэв. Цар тахлын улмаас иргэдийн худалдан авах чадвар буурсан, тансаг зэрэглэлийн бүтээгдэхүүнүүдийн арилжаа багассан, эрэлт ерөнхийдөө буурсан зэрэг шалтгаануудын улмаас манай улсын инфляцийн түвшин 2020 онд сүүлийн жилүүдэд байгаагүй доод түвшинд очсон боловч жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд үнийн өсөлт буюу инфляцийн түвшин муугаар гэж 45.8%, маш муугаар нөлөөлж байна гэж 47.7% нь хариулсан. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцсон 20 компани тутмын 19-д нь инфляцийн дарамт хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байна. Харин төгрөгийн ханш үйл ажиллагаанд нь нөлөө үзүүлдэггүй гэж 65 компани хариулсан нь нийт оролцогчдын 4.2%-ийг эзэлж байна. Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн ханш ам.доллар болон юаны эсрэг сулрах нь бизнес эрхлэгчдийн 43%-д муугаар 38.1%-д маш муугаар нөлөөлж байна гэжээ. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын 81.1% нь төгрөгийн ханшийн сулралд гүн өртөмтгий

байна. Учир нь өмнөх судалгаанд үзүүлсэнчлэн нийт ЖДБЭ-дийн 70% нь түүхийн эд, орцынхоо 26-100 хүртэлх хувийг импортын бүтээгдэхүүн, нөөцөөр хангадаг билээ. Гадаадын хөрөнгө оруулалт үйл ажиллагаанд нь нөлөөлдөг эсэхэд мэдэхгүй гэж хариулсан ЖДБЭ-д маш өндөр буюу 42% байгааг анхаарч үзэх нь чухал. Цаашид гадаадын хөрөнгө оруулалтын үр шимийн талаар энэ салбарт сурталчлан таниулах, түүнийг төрийн бодлогоор дэмжих, тогтвортой байдлыг нь хангаж өгөх нь төрийн хувьд чухал сорилт болжээ гэж үзэж байна.

Судалгаанд оролцсон нийт ЖДБЭ-дийн ердөө 4% хувь буюу 58 компани бүтээгдэхүүн, үйлчилгээгээ экспортлодог ажээ. Эдгээр компаниудын бараг 20% нь цар тахал, 17.8% нь худалдан авагч орны импортын татвар өндөр, 10.8% нь хил гаалийн ажилтнуудын хүнд суртал, 9.6% нь экспортлогчдод төрийн дэмжлэг сул байдаг нь тус салбарын хамгийн том бэрхшээлүүд гэж үзсэн.

Цар тахлын улмаас үүссэн хил, гаалийн хорио цээрийн дэглэм болон Замын-Үүд, Алтанбулаг боомтууд дахь бараа бүтээгдэхүүний бөөгнөрөл, хоцрогдол нь ЖДБЭ-дэд хэрхэн нөлөөлж буйг судлан үзлээ. Тухайн боомтууд дээр үүсээд буй ачаа, тээврийн саатал, түүнийг дагасан хүнд суртал, өртөг зардлын өсөлт судалгаанд оролцсон нийт бизнес эрхлэгчдийн 71.4%-д “мүү” болон “маш мүүгаар” нөлөөлж байна. Иймд манай улсын хувьд хилийн боомтуудын хорио цээрийн дэглэмийн стандартыг боомтын ачаалал, багтаамж, ажиллах чадвартай нь уялдуулан дорвитой шинэчлэх шаарлагатай болсныг харуулж байна.

Эцэст нь жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт татварын төрөл бүрийн хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшуулал олгож бизнесийн эко орчныг дэмжих шаардлагатай байна. Мөн бодлого боловсруулагчдын зүгээс “төрийн үйлчилгээний хүнд суртлыг арилгах” арга хэмжээ авах нь энэ салбарыг урт хугацаанд, тогтвортой дэмжих удаах бодлогын арга хэмжээ болж байна. Цар тахлын үед эмэгтэй захиралтай жижиг, дунд бизнес эрхлэгчид эрэгтэй захиралтай ижил түвшний компаниудаасаа илүү сайн ажиллаж байна. Хямралын үед ЖДҮ салбарын дундаж Монгол эмэгтэй захирал дундаж эрэгтэй захирлаас илүү үр дүнтэй удирдлага, зохион байгуулалт хийж оновчтой шийдвэрүүд гаргаж байна гэсэн дүгнэлт хийгдэв. Засгийн газраас “цар тахлын үед эдийн засгаа сэргээх” бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд байгаа онохгүй байна. Жишээ нь ипотекийн 6%-ийн зээл барилгын болон боловсруулах үйлдвэрлэлийн салбар дахь 293 компанийн ердөө 10 компанид тодорхой хэмжээгээр эерэг нөлөө үзүүлсэн. Мөн хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй зээлийн төрөл бүрийн дэд хөтөлбөрүүд, төсвийн дэмжлэгийн талаар ХАА-н компаниудын 86.3 хувь нь эдгээр хөтөлбөр “нөлөөгүй” эсхүл “мэдэхгүй” гэж хариулсныг анхаарууштай.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуй нэгж
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АХБ	Азийн Хөгжлийн Банк
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДБЭ	Жижиг, дунд бизнес эрхлэгчид
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУВС	Олон улсын валютын сан
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгааны ажлын цагалбар.....	8
Зураг 2. Аж ахуйн нэгж, байгууллага, үйл ажиллагаа эрхлэлтийн байдал	9
Зураг 3 . Дэд олонлогийн бүтэц, ерөнхий мэдээлэл	10
Зураг 4. Дэд олонлогийн газарзүйн онцлог (орон нутгаар, 1500 оролцогчийн хувьд)	11
Зураг 5. Түүвэр судалгааны бодит оролцоо (орон нутгаар, 1545 оролцогчтой).....	11
Зураг 6. Судалгаанд оролцсон ЖДБЭ-дийн үйл ажиллагааны чиглэл.....	13
Зураг 7. Судалгааны хэлбэрүүд	13
Зураг 8. Түүвэр судалгааны үр дүнг цуглуулсан виртуал платформ	14
Зураг 9. Виртуал платформын “суурь” шинжилгээ	14
Зураг 10. Байгууллагын үндсэн ажилтны тоо.....	15
Зураг 11. ЖДБЭ-ийн үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа (жилээр)	15
Зураг 12. Захирлуудын насны харьцаа	16
Зураг 13. Захирлуудын хүйсийн харьцаа	16
Зураг 14. Захирлуудын боловсрол.....	16
Зураг 15. Захирлуудын мэргэжил	16
Зураг 16. Захирлуудын мэргэшлийн түвшин.....	16
Зураг 17. ЖДБЭ-дийн анхны санхүүжилтийн эх үүсвэр.....	17
Зураг 18. ЖДБЭ-дийн жилийн борлуулалтын орлого	17
Зураг 19. Цар тахлын ЖДБЭ-дийн борлуулалтын орлогод үзүүлж буй нөлөө.....	18
Зураг 20. Цар тахлын ЖДБЭ-дийн ашигт ажиллагаанд үзүүлж буй нөлөө.....	18
Зураг 21. ЖДБЭ-дийн санхүүжилтийн хэрэгцээ	18
Зураг 22. ЖДБЭ-дийн санхүүжилтийн эх үүсвэр	18
Зураг 23. Санхүүжилт авч чадаагүй үндсэн шалтгаанууд.....	19
Зураг 24. Зээл авахад барьцаалсан хөрөнгө	19
Зураг 25. Цар тахлын үед тулгамдаж буй санхүүгийн хүндрэлүүд	20
Зураг 26. Цар тахлын үед тулгамдаж буй бусад хүндрэлүүд.....	20

Зураг 27. Цар тахлаас улбаасан орон тооны цомхотгол	21
Зураг 28. Цар тахлаас тэсэн гарах чадамж	21
Зураг 29. ЗГ-аас 2020 онд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр нөлөө (1)	21
Зураг 30. ЗГ-аас 2020 онд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр нөлөө (2)	22
Зураг 31. ЗГ-аас 2021 онд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр нөлөө (1)	23
Зураг 32. ЗГ-аас одоо хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр нөлөө (2)	24
Зураг 33. ЗГ-аас 2021 онд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр нөлөө (3)	25
Зураг 34. Боловсон хүчний хангамж	26
Зураг 35. Боловсон хүчний үр чадвар	26
Зураг 36. Боловсон хүчний хангамж (салбаруудаар)	27
Зураг 37. Ажилчдыг давтан сургах хэрэгцээ, шаардлага ба судалгаа, хөгжүүлэлт	28
Зураг 38. ЖДБЭ-дийн тоног төхөөрөмжийн хангамж, антпренер чадавхи ба инноваци	29
Зураг 39. Тоног төхөөрөмжийн хангамж (зарим салбаруудаар)	29
Зураг 40. Шинэ бүтээгдэхүүн/үйлчилгээ нэвтрүүлсэн эсэх (салбаруудаар)	30
Зураг 41. Хүчин чадлын ашиглалт болон дотоодын ханган нийлүүлэлт	31
Зураг 42. Эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал	32
Зураг 43. Инфляци	32
Зураг 44. Төгрөгийн ханш	32
Зураг 45. Гадаадын хөрөнгө оруулалт	32
Зураг 46. Бүтээгдэхүүн, үйлчилгээгээ экспортлодог эсэх	33
Зураг 47. Нийт борлуулалтын орлогод эзлэх экспортын орлогын хувь	33
Зураг 48. Бүтээгдэхүүн экспортлоход тулгарч буй үндсэн хүндрэлүүд	34
Зураг 49. Бүтээгдэхүүн импортлоход тулгарч буй үндсэн хүндрэлүүд	34
Зураг 50. Замын-Үүд, Алтанбулаг боомтуудын нөхцөл байдал	35
Зураг 51. Дэд бүтцийн салбарын бэрхшээлүүд	35
Зураг 52. Бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулахад үүсч буй хүндрэл бэрхшээлүүд	37
Зураг 53. Ирэх жил ийм төрлийн судалгаанд дахин оролцох эсэх	46

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Түүвэр судалгааны бодит оролцоо (аймаг, дүүргүүдээр)	12
Хүснэгт 2. Ажиллах хүчний хангамж (бүс, нийслэлээр).....	26
Хүснэгт 3. Борлуулалтын орлого ба ашигт ажиллагаа (экспорт, экспортын бусаар).....	35
Хүснэгт 4. УБ хот, орон нутгийн дэд бүтцийн салбар дахь бэрхшээлүүд.....	36
Хүснэгт 5. УБ хот, орон нутгийн ЖДБЭ-дэд тулгарч буй борлуулалтын бэрхшээлүүд.....	37
Хүснэгт 6. ЖДБЭ-дийг дэмжихэд зориулсан арга хэмжээнүүдийн эрэмбэлэлт	38
Хүснэгт 7. Цар тахлын үед эмэгтэй, эрэгтэй захирлуудад ажлын ялгаа гарсан уу?	40
Хүснэгт 8. Цар тахлын үед эмэгтэй, эрэгтэй захирлуудад ажлын ялгаа гарсан уу?	41
Хүснэгт 9. Боловсролын түвшин хямралын менежментэд эерэгээр нөлөөлөх үү?	41
Хүснэгт 10. Төсвийн зорилтот хөтөлбөрүүд үр дүн өгч байна уу?.....	42
Хүснэгт 11. Борлуулалт болон шинэ дэвшилтэд бүтээгдэхүүний хоорондын уялдаа.....	43
Хүснэгт 12. Борлуулалт хэмжээ болон үүсч буй хүндрэлүүдийн хоорондын уялдаа.....	43
Хүснэгт 13. Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн ЖДБЭ-дэд үзүүлэх ялгаатай нөлөөллүүд	44
Хүснэгт 14. Төгрөгийн ханшийн уналт ба экспортлогч ЖДБ эрхлэгчид.....	45

Хүснэгт 15. Томоохон хилийн боомтуудын нөхцөл байдал ба экспортлогч ЖДБ эрхлэгчид	45
Хүснэгт 16. Томоохон хилийн боомтуудын нөхцөл байдал ба экспортлогч ЖДБ эрхлэгчид	46

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. ДНБ-ний өсөлт, салбараар	48
График 2. Эдийн засгийн жилийн өсөлт	48
График 3. Ажилгүйчүүд ба ажилгүйдлийн түвшин	50
График 4. Өрхийн орлого ба зарлага (жилийн өсөлт)	50
График 5. Банкны салбарын зээлийн үлдэгдэл (салбараар)	51
График 6. Банкны салбарын чанаргүй зээлийн хувь хэмжээ	51
График 7. Жилийн инфляци	52
График 8. Хүүний түвшин (тухайн сард шинээр)	52
График 9. Валютын ханш	53
График 10. Гадаад валютын албан нөөц (сая ам.д)	53
График 11. Төсвийн тэнцэл (их наяд төг, сараар)	Error! Bookmark not defined.
График 12. Дэлхийн засгийн төлөв	54
График 13. Эдийн засгийн өсөлт, инфляцийн төсөөлөл (MeARC)	55

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЖИЖИГ, ДУНД БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГАА


1.1. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДСЭН ЗОРИЛГО

Монгол Улс дахь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн (цаашид ЖДБЭ гэх) өрсөлдөх чадварыг үнэлэх, өрсөлдөх чадвараа сайжруулах цаашдын хэрэгцээ шаардлага болон бараа бүтээгдэхүүн экспортлоход тулгардаг саад, бэрхшээлийг илүү сайн тодорхойлж ойлгох нь уг судалгааны үндсэн зорилго байв. Түүнчлэн бүхий л улсын бизнес эрхлэгчдэд ялангуяа жижиг, дунд бизнесийн салбарт учирч буй “Коронавирус-19” цар тахлын сөрөг нөлөөг манай улсын ЖДБЭ-дийн хувьд гүнзгийрүүлэн судлах нь уг судалгааны ажлын дараагийн зорилго юм. Энэхүү судалгааны ажлын нэгтгэсэн үр дүнг хувийн сектор, бизнесийн орчин болон экспортыг дэмжих зорилго бүхий төрийн байгууллага, бизнесийн холбоод, хөрөнгө оруулагч нарт хуваалцах, цаашид бодлогын шийдэл болгон танилцуулах нь чухал ач холбогдолтой юм.

1.2. АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ, ЦАГАЛБАР

Монгол улсын жижиг дунд, бизнес эрхлэгчдийн сул, давуу тал болон бизнесийн экосистемийг үнэлэх, ирэх жилүүдийн эдийн засаг төлөв байдлаас ЖДБЭ-дийн бизнесийн орчинд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлоход энэхүү ажлын ач холбогдол оршино. Уг судалгааны ажлын хүрээнд Улаанбаатар хот болон бүсийн төвүүдээс жижиг, дунд бизнес эрхэлж буй 1500-аас багагүй тооны аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг хамруулахаар зорьсон.

Зураг 1. Судалгааны ажлын цагалбар



Түүвэр судалгааны асуулгын анхдагч дизайныг гүйцэтгэгч тал 2021 оны 7 сард боловсруулж улмаар захиалагч “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран уг дизайнд зохих шинэчлэл, өөрчлөлтүүдийг хийсэн бөгөөд үүний дараа түүврийн бүтэц, хэмжээг тодорхойлох ажлыг гүйцэтгэсэн. Ингэхдээ жижиг, дунд бизнес эрхлэгчдийн эх олонлогийг хамгийн сайн төлөөлөх “дэд” олонлогийг нийгэм, жижиг дунд бизнесийн орчин, онцлогт нь нийцүүлэн боловсруулж улмаар статистикийн “бүлэгчилсэн түүвэр”-ийн аргыг ашиглан судалгаанд оролцогчдыг тодорхойлсон.

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг календарын хоёр долоо хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн бөгөөд мэдээллийн санг цэвэршүүлж, улмаар ангилах, эрэмбэлэх, дүн


шинжилгээ хийх ажлууд хийгдсэн. Уг түүвэр судалгааны эцсийн үр дүнг улсын эдийн засгийн богино болон дунд хугацааны төлөв байдалтай уялдуулан жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бизнесийн орчныг сайжруулахад чиглэсэн бодлогын зөвлөмж боловсруулахад ашиглав.

1.3. СУДАЛГААНЫ АЖЛЫН ТҮҮВЭРЛЭЛТ, БИЗНЕСИЙН ОРЧИН-ГАЗАРЗҮЙН ОНЦЛОГУУД

Үндэсний статистикийн хорооноос боловсруулсан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг 2021 оны 2 дугаар улирлын байдлаар авч түүвэр судалгааны “дэд” олонлог бүрдүүлэхэд ашигласан. Улсын хэмжээнд нийт 210893 байгууллага бүртгэлтэй байга боловч тайлант хугацаанд 93560 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж буй нь нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн ердөө **44.3** хувийг эзэлж байна.


Зураг 2. Аж ахуйн нэгж, байгууллага, үйл ажиллагаа эрхлэлтийн байдал

Аж ахуйн нэгж, байгууллага, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар



Эх сурвалж:ҮСХ

Цар тахлын нөлөө, түүнтэй уялдсан олон удаагийн бүрэн болон хэсэгчилсэн хөл хорионы улмаас манай улсын бизнесийн орчин сүүлийн үед ихээхэн хүндэрсэн нь үйл ажиллагаа явуулаагүй, түр болон бүрэн зогссон аж ахуйн нэгжийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэмэгдсэнээр харагдаж буй юм. Энэхүү хүндэрсэн нөхцөл байдал нь газар дээрх судалгааны ажлын явцад давхар батлагдсан бөгөөд энэ талаар судалгааны үр дүн хэсэгт дэлгэрэнгүй үзүүлэх болно.



Эх олонлогийн хувьд үйл ажиллагаа явуулж буй нийт 93560 аж ахуйн нэгж, байгууллагын **87.6** хувийг бичил, **9.7** хувийг жижиг, **2.7** хувийг дунд болон том хэмжээний бизнесийн байгууллагууд эзэлж байна. Энэхүү ангилалыг “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” хуулийн дагуу голлох хувьсагч ажилтны тоогоор хийсэн.

Дэд олонлогийн чанарыг сайжруулах зорилгоор нөхөрлөл, хоршоо болон хувиараа бизнес эрхлэгч иргэдийг судалгаанд нэмж хамруулсан бөгөөд газар тариалангийн болон уул уурхайн үйлдвэрлэл түлхүү хөгжсөн орон нутаг, аймгуудад нөхөрлөл, хоршооны бизнес бусад аймгуудтай харьцуулахад илүү хөгжжээ.

Эх олонлогийн үндсэн шинж чанаруудыг зохих ёсоор проекцлон буулгасан дэд олонлогийг Монгол Улсын “Бизнес, регистрийн сан”-д бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудаас нөхцөлт санамсаргүй түүврийн аргаар 5000 жижиг, дунд бизнес эрхлэгчдийн ерөнхий мэдээллийг татан авч бүрдүүлэлт хийсэн. Энэхүү дэд олонлогт 1-9 ажилтантай 3843 бичил бизнес эрхлэгч, 10-19 ажилтантай 421 жижиг бизнес эрхлэгч, 20-49 ажилтантай 467 жижиг бизнес эрхлэгч, 50-200 ажилтантай 269 дунд хэмжээний бизнес эрхлэгчид хамрагдсан байв. Зураг 3-ыг үзнэ үү.

Зураг 3. Дэд олонлогийн бүтэц, ерөнхий мэдээлэл

DD	Нэр	Байгууллагын төрөл	Өмчийн төрөл	Аймаг, нийслэл	Сум, дүүрэг	Утас1	Утас2	Салбарын нэр	Үйл ажиллагааны чиглэлийн нэр
1	Амуу агро	Компани	Хувийн	Улаанбаатар	Сонгино хайрхан			А	Хөдөө аж ахуй, ойн-Бусад амьтан өсгөх үйл ажиллагаа
2	Хөвчийн бүргэд	Компани	Хувийн	Улаанбаатар	Баянзүрх	99064063		А	Хөдөө аж ахуй, ойн-Мод тарих үйл ажиллагаа болон бусад ойн аж ахуй
3	Ачид Эго ХХК	Компани	Хувийн	Улаанбаатар	Сүхбаатар	99113882		А	Хөдөө аж ахуй, ойн-Хүнсний ногоо болон амтат гуа, үндэст болон буцлуу
4	Агро стейт	Компани	Хувийн	Улаанбаатар	Хан-Уул	70007771	99108807	А	Хөдөө аж ахуй, ойн-Мод тарих үйл ажиллагаа болон бусад ойн аж ахуй
5	Монголжин трейд ХХК	Компани	Хувийн	Хан-Уул	Сүхбаатар	99083302	98103302	А	Хөдөө аж ахуй, ойн-Ур тариа (цагаан будааг оруулахгүйгээр), буурцагт
6	Адвентур хант	Компани	Хувийн	Улаанбаатар	Чингэлтэй			А	Хөдөө аж ахуй, ойн-Нэг наст бусад ургамал тариалалт
7	Бест агро ланд ХХК	Компани	Хувийн	Улаанбаатар	Сүхбаатар			А	Хөдөө аж ахуй, ойн-Хөлийн фермерийн аж ахуй
8	Сод Агро	Компани	Хувийн	Улаанбаатар	Сүхбаатар	99161232	99011826	А	Хөдөө аж ахуй, ойн-Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжсэн туслах үй
9	БСКА ХХК	Компани	Хувийн	Улаанбаатар	Хан-Уул			А	Хөдөө аж ахуй, ойн-Хүнсний ногоо болон амтат гуа, үндэст болон буцлуу
10	Морул скай групп	Компани	Хувийн	Улаанбаатар	Чингэлтэй			А	Хөдөө аж ахуй, ойн-Ан агнуур, түүнд холбогдох үйл ажиллагаа
11	Экошажир	Компани	Хувийн	Улаанбаатар	Сонгино хайрхан	96036502	99196502	А	Хөдөө аж ахуй, ойн-Үхэр, сарлаг өсгөх үйл ажиллагаа
12	Мөхч ногоон мэд ХХК	Компани	Хувийн	Улаанбаатар	Сонгино хайрхан	99137020		А	Хөдөө аж ахуй, ойн-Мод тарих үйл ажиллагаа болон бусад ойн аж ахуй
13	Тангрийн цагаан шувуу	Компани	Хувийн	Улаанбаатар	Хан-Уул			А	Хөдөө аж ахуй, ойн-Хүнсний ногоо болон амтат гуа, үндэст болон буцлуу
14	Чан мэд очир ХХК	Компани	Хувийн	Улаанбаатар	Чингэлтэй	91998205		А	Хөдөө аж ахуй, ойн-Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжсэн туслах үй
15	Хамтан төгөл ХХК	Компани	Хувийн	Улаанбаатар	Баянзүрх	99158515		А	Хөдөө аж ахуй, ойн-Мод тарих үйл ажиллагаа болон бусад ойн аж ахуй
16	Юргэнфреш ХХК	Компани	Хувийн	Улаанбаатар	Сүхбаатар			А	Хөдөө аж ахуй, ойн-Хүнсний ногоо болон амтат гуа, үндэст болон буцлуу
17	Цэцэгт ногоон хөндий	Компани	Хувийн	Улаанбаатар	Хан-Уул	89893944, 89	88845660	А	Хөдөө аж ахуй, ойн-Олон наст бусад ургамал тариалалт
18	Шинэ чулуун талбай	Компани	Хувийн	Улаанбаатар	Сүхбаатар			А	Хөдөө аж ахуй, ойн-Хөлийн фермерийн аж ахуй
19	Арсайн хурхээ ХХК	Компани	Хувийн	Улаанбаатар	Сүхбаатар	96003809	99183809	А	Хөдөө аж ахуй, ойн-Олон наст бусад ургамал тариалалт
20	Хүйтэн уул групп ХХК	Компани	Хувийн	Улаанбаатар	Баянзүрх	88070878	99003759	А	Хөдөө аж ахуй, ойн-Ургамал тарих, ургуулах үйл ажиллагаа
21	Одогол ХХК	Компани	Хувийн	Улаанбаатар	Сүхбаатар	98623369	98981214	А	Хөдөө аж ахуй, ойн-Хүнсний ногоо болон амтат гуа, үндэст болон буцлуу

Дээрх зурагт үзүүлсэн ЖДБЭ-дийн дэд олонлогт тухайн аж ахуйн нэгжийн салбар, үйл ажиллагааны чиглэл тусгагдсанаас гадна байгууллагын төрөл, газарзүйн байршлын талаарх мэдээлэл багтсан. Судалгаа явагдах хугацаанд коронавирус цар тахлын улмаас зарим орон нутаг, аймгуудад хөл хорио тавигдсан байдалтай байсан тул тухайн аж ахуйн нэгжтэй утсаар холбогдож судалгааны CATI буюу зайнаас авах хэлбэрийг түлхүү ашигласан.

Захиалагчийн зүгээс бүх 21 аймгийг судалгаанд хамруулах шаардлагагүй гэж үзсэн бөгөөд Монгол Улсын “Алсын хараа 2050” хөтөлбөрт тусгагдсан бүсчилсэн хөгжлийн шинэ бүтцээр 6 бүс тус бүрээс дор хаяж 1 аймгийг оролцуулан дэд олонлогийг бүрдүүлэх чиглэл өгсөн. Гэвч бидний боловсруулсан дэд олонлогийн мэдээллийн чанар өндөр, аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох утас 5 хүртэлх хувилбартай байсан тул Улаанбаатар хотын 8 дүүрэг, бүх 21 аймгийг оролцуулж 1545 ЖДБЭ-дийг хамруулсан түүвэр судалгааг амжилттай хийж гүйцэтгэлээ.

Зураг 4-т эх олонлогийн газар зүйн үндсэн шинж чанарыг түүвэр судалгаанд оновчтой хөрвүүлэхийн тулд Улаанбаатар хотын дүүргүүд болон бүх 21 аймгуудаас

судалгаа авах ЖДБЭ-дийн шаардлагатай дундаж тоог үзүүлэв. Ингэхэд үйлдвэрлэл, үйлчилгээ бусдаас илүү хөгжсөн аймаг болон бүс нутгуудаас оролцох ЖДБЭ-дийн тоо бусад аймгуудаас харьцангуй өндөр байв. Ялангуяа хангайн болон говийн бүсэд орших аймгуудаас авах судалгааны тоо зүүн болон алтайн бүсийн аймгуудаас авах судалгааны тооноос зарим тохиолдолд 2-3 дахин өндөр байв.

Зураг 4. Дэд олонлогийн газарзүйн онцлог (орон нутгаар, 1500 оролцогчийн хувьд)



Тооны хувьд Сэлэнгэ аймгаас 40 ЖДБЭ-дийг судалгаанд хамруулах шаардлагатай байсан нь хамгийн өндөр байсан бол Говьсүмбэр аймгаас хамгийн бага буюу 5 аж ахуйн нэгжийг хамруулах шаардлагатай байв. Түүнчлэн баруун бүсээс Ховд аймаг, зүүн бүсээс Дорнод аймаг, говийн бүсээс Өмнөговь аймаг, алтайн бүсээс Баянхонгор аймаг, Хангайн бүсээс Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймгууд илүү анхаарал татсан. Дэд олонлогт багтсан бүх 5000 жижиг, дунд бизнес эрхлэгчтэй холбогдож, чанарын шаардлага хангасан 1545 ширхэг судалгаа авахад бодит оролцоо Зураг 5-д үзүүлснээр гарсан.

Зураг 5. Түүвэр судалгааны бодит оролцоо (орон нутгаар, 1545 оролцогчтой)



Увс, Ховд, Өмнөговь, Дорнод, Завхан, Сэлэнгэ аймгийн жижиг, дунд бизнес эрхлэгчид судалгаанд хамгийн идэвхитэй оролцсон бөгөөд үүнд судалгааны багууд Завхан, Увс, Ховд, Баянхонгор аймгуудад газар дээр нь очиж ажилласантай мөн холбоотой байв.

Улаанбаатар хотын хувьд Сүхбаатар, Баянгол, Хан-Уул, Баянзүрх дүүргийн бизнес эрхлэгчид идэвхитэй оролцсон бол Чингэлтэй, Сонгинохайрхан, Багануур дүүргийн бизнес эрхлэгчид харьцангуй цөөн оролцсоныг Хүснэгт 1-ээс дэлгэрэнгүй үзнэ үү.

Хүснэгт 1. Түүвэр судалгааны бодит оролцоо (аймаг, дүүргүүдээр)


№	Бүс	Аймаг	ААН-н тоо (эх олонлог)	ААН-н тоо (дэд олонлог)	Бүсийн дүн	Бодит	Хувь
1	Баруун бүс	Баян-Өлгий аймаг	23	42	82	158	10.2
2		Ховд аймаг	34	53			
3		Увс аймаг	25	63			
4	Хангайн бүс	Завхан аймаг	21	34	210	197	12.8
5		Хөвсгөл аймаг	26	30			
6		Архангай аймаг	17	9			
7		Булган аймаг	19	24			
8		Сэлэнгэ аймаг	40	31			
9		Дархан-Уул аймаг	38	30			
10		Орхон аймаг	30	26			
11		Төв аймаг	19	13			
12	Алтайн бүс	Говь-Алтай аймаг	13	15	56	75	4.9
13		Өвөрхангай аймаг	21	28			
14		Баянхонгор аймаг	22	32			
15	Говийн бүс	Дорноговь аймаг	18	24	63	90	5.8
16		Дундговь аймаг	10	12			
17		Өмнөговь аймаг	30	51			
18		Говьсүмбэр аймаг	5	3			
19	Зүүн бүс	Хэнтий аймаг	19	13	57	67	4.3
20		Дорнод аймаг	26	34			
21		Сүхбаатар аймаг	12	20			
22	Улаанбаатар	Хан-Уул	122	187	1032	958	62.0
23		Баянзүрх	227	181			
24		Баянгол	208	201			
25		Сүхбаатар	220	280			
26		Чингэлтэй	115	79			
27		Сонгинохайрхан	119	19			
28		Налайх	12	8			
29		Багануур	8	3			
30		Багахангай	1	0			
Орон нутаг					468	587	38.0
Улаанбаатар хот					1032	958	62.0
Нийт					1500	1545	100

Бүсчилж үзвэл Хангайн бүсээс бусад бүх бүсүүд буюу Баруун, Алтайн, Говийн болон Зүүн бүсийн аймгуудаас авах судалгааны тоо зорилтот түвшнээс давсан бол Улаанбаатар хотын хувьд 1032 аж ахуйн нэгжээс судалгаа авах зорилт тавьсан ч шаардлага хангасан 958 судалгааг авав. Нийслэл хотын хувьд зорилтот түвшинд хараахан хүрээгүй ч авсан судалгааны тоо эх олонлогийг оновчтой төлөөлөх хангалттай чадвартай бөгөөд дүүргээр үр дүнг ангилан боловсруулах шаардлагагүй нь дүн шинжилгээ хийх явцад тодорсон.


Дүгнэж үзвэл нийт судалгаанд оролцсон 1545 аж ахуйн нэгжийн 62 хувь нь Улаанбаатар хотод, 38 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд энэ нь эх олонлогийг газарзүйн байршлын хувьд хангалттай сайн төлөөлөх чадвартай гэсэн үг.

Судалгаанд оролцсон нийт жижиг, дунд бизнес эрхлэгчдийн **45%** нь буюу 695 аж ахуйн нэгж бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт, **11%** нь буюу 169 аж ахуйн нэгж боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бол 124 барилгын компани, 73 хөдөө аж ахуйн компани, 36 аялал жуулчлалын компани мөн оролцлоо. Эндээс үзэхэд манай улсын ЖДБЭ-дийн хувьд бараг тэн хагас нь нэмүү өртөг багатай худалдааны салбарт ажилладаг бол экспортын чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг маш цөөхөн компани байдаг нь анхаарал татав. Зураг 6-аас харна уу.

Зураг 6. Судалгаанд оролцсон ЖДБЭ-дийн үйл ажиллагааны чиглэл



Зураг 7. Судалгааны хэлбэрүүд



Захиалагчаас өгсөн хүсэлтийн дагуу нийт 1064 судалгааг зайнаас буюу CATI хэлбэрээр, 481 судалгааг биечлэн буюу газар дээр нь CAPI хэлбэрээр хийж гүйцэтгэв. Цар тахлын уршиг, хөл хорионы улмаас биечлэн хийгдэх судалгааны хэлбэр нь ихээхэн сорилттой тулгарсан боловч хангалтай тооны судалгааг уг хэлбэрээр хийж чадсан.


1.4. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, ЯВЦЫН БОЛОН ЭЦСИЙН ХЯНАЛТ

Судалгаанд оролцсон нийт жижиг, дунд бизнес эрхлэгчдийн судалгааны үр дүнг онлайн хэлбэрт *Google Forms* веб суурьт “програм хангамж” ашиглан бүрдүүлсэн (Зураг 8-г үзнэ үү). Судалгааны ажилтнуудад дүрс бичлэгийн болон дуу хураагуурын хяналтыг газар дээр нь, судалгааны чанарын хяналтыг зайнаас өдөр бүр хийж гүйцэтгэсэн.

Зураг 8. Түүвэр судалгааны үр дүнг цуглуулсан виртуал платформ

Судалгааны энэхүү платформыг ашигласнаар судалгаанд оролцогч болон судлаачийн санамсаргүй алдаа гаргах магадлалыг бууруулж, зайнаас хяналт тавих боломжийг 24/7 хэлбэрт шилжүүлдэг. Түүнчлэн уг платформ нь түүвэрт “суурь” шинжилгээ хийх боломжтойг Зураг 9-т үзүүлэв. Гэвч ахисан шатны судалгааг эдийн засгийн шинжилгээ, түүвэр судалгааны тухайлсан программ хангамжуудаар тусад нь хийж гүйцэтгэсэн болно.

Зураг 9. Виртуал платформын “суурь” шинжилгээ



Судалгааны явцад “суурь” шинжилгээг уг платформыг ашиглан өдөр бүр хийх нь түүврийн тархалт болон үр дүнд чанарын хяналт хийхэд чухал ач холбогдолтой байсан бөгөөд судалгааны сүүлийн өдрүүдэд зорилтот салбар, бизнесийн түвшин, газарзүйн онцлогыг ханган чиглүүлэхэд дэмжлэг болсон.

1.5. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг үнэлэхийн тулд олон улсад түгээмэл хэрэглэгддэг аргачлалыг дараах бүтцийн дагуу ашиглав. Үүнд:


1. Санхүү, эдийн засгийн өрсөлдөх чадвар

2. Ажиллах хүчний өрсөлдөх чадвар
3. Тоног төхөөрөмжийн хангамж болон антепренер өрсөлдөх чадвар
4. Макро эдийн засгийн өрсөлдөх чадвар
5. Экспортын өрсөлдөх чадвар
6. Дэд бүтцийн өрсөлдөх чадвар


Дурдагдсан эдгээр өрсөлдөх чадваруудын нарийвчилсан үнэлгээг үзүүлэхийн өмнө судалгаанд оролцсон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн ерөнхий мэдээллүүдийг танилцуулья.

Тус судалгаанд оролцсон 1219 компани 1-9 ажилтантай байсан бол, 200 компани 10-19 ажилтантай, 80 компани 20-49 ажилтантай, 46 компани 51-200 ажилтантай байв. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцсон 10 ЖДБЭ тутмын 8 нь **бичил** буюу 1-9 ажилтантай бол 18% нь **жижиг**, 3% нь **дунд** түвшний компанид хамаарч байна. Манай улсын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 80 хувь нь 1-9 ажилтантай буюу бичил хэлбэрийн бизнест хамаарч буй нь энэ сегментэд тохирсон санхүүгийн бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ их буйг илтгэнэ. Түүвэр судалгаанд оролцсон эдгээр компаниудын ажилтны тоонд үндэслэсэн бүтэц нь эх олонлогийн ерөнхий бүтэцтэй ижилэвтэр байв. Зураг 10-ыг харна уу.

Зураг 10. Байгууллагын үндсэн ажилтны тоо




Зураг 11. ЖДБЭ-ийн үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа (жилээр)




Мөн энэ салбарт үйл ажиллагаа эрхэлж буй 5 компани тутмын 1 нь байгуулагдаад 3 жил хүрээгүй бол 4 компани тутмын 1 нь 4-6 жил, 5 компани тутмын нэг нь 7-9 жил, 3 компани тутмын 1 нь 10-аас дээш жил оршин тогтножээ. Өөрөөр хэлбэл жижиг, дунд бизнесийн салбарт 3 компани тутмын нэг нь буюу ойролцоогоор 34.8 хувь нь бизнес, үйл ажиллагааны хувьд тогтворжсон, байнгын харилцагчтай болсон шинжтэй байна. Зураг 11-ийг харна уу.

Судалгаанд оролцсон ЖДБЭ-дийн ердөө 7.2% нь 18-30 насны залуус бол 3 захирал тутмын 2 нь 31-50 насны, 4 захирал тутмын 1 нь 51-ээс дээш настай байна. Иймд залуу бизнес эрхлэгч, бизнес эхлүүлэх зорилготой залуучуудад бизнесийн чиглэлийн бүх төрлийн сургалтыг тухайлбал, гарааны бизнес, антепренер чадавхи нэмэгдүүлэх зэргээр идэвхижүүлэх шаардлагатай нь харагдаж байна (Зураг 12).

Зураг 12. Захирлуудын насны харьцаа




Зураг 13. Захирлуудын хүйсийн харьцаа




Түүнчлэн манай улсад жижиг, дунд бизнес эрхэлж буй захирлуудын дунд хүйсийн ялгаа тооны хувьд бараг байхгүй буюу дунджаар 51 эрэгтэй захиралд 49 эмэгтэй захирал ногдож байна (Зураг 13). Их Британийн Лондон хотын Бизнесийн сургуулийн эрдэмтдийн багаас жил бүр боловсруулан танилцуулдаг “Дэлхийн Антепренершип Илтгэл 2020”-д судалгаанд оролцсон нийт жижиг, дунд бизнес эрхлэгчдийн (43 орон) хувьд хүйсийн харьцаа дунджаар 10 эрэгтэй захиралд 6 эмэгтэй захирал ногдож буйг харуулсан. Үүнтэй харьцуулахад манай улсын ЖДБ-ийн салбарт эмэгтэй удирдагч, захирлуудын тоо эрчүүдтэй харьцуулахад хангалттай өндөр байж чаддаг байна. Энэ нь зарим банк, санхүүгийн байгууллагаас эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжид хүүгийн хөнгөлөлттэй зээл олгох практик нэвтэрсэн нь нөлөөлсөн байх талтай. Сонирхолтой нь Азийн бүсээс Казахстан, Индонези, Саудын Араб гэсэн 3 улсад эмэгтэй захирлын тоо эрэгтэй захирлын тооноос өндөр байдаг ажээ¹.

Зураг 14. Захирлуудын боловсрол



Зураг 15. Захирлуудын мэргэжил



Зураг 16. Захирлуудын мэргэшлийн түвшин




Тусгай мэргэшил эзэмшсэн захирлуудын 29.1% нь худалдаа, үйлчилгээний, 21.6% нь барилга, 4.8% нь ХАА, фермерийн чиглэлээр суралцжээ.

Монгол Улс дахь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд өөрийн хөрөнгө нь гарааны санхүүжилтийн үндсэн эх үүсвэр (62%) болж байна. Мөн 5 бизнес эрхлэгч тутмын 1 нь банк болон ББСБ, ХЗХ-ноос зээл авсан бол 14% нь гэр бүл, эцэг эхийн хөрөнгөнд суурилжээ. Харамсалтай нь олон улсын төслийн зээл, “Жижиг, дунд

¹ Дэлгэрэнгүй илтгэлийг эндээс үзнэ үү. <https://www.gemconsortium.org/report/gem-20202021-global-report>

үйлдвэрлэлийн сан”, гадаадын хөрөнгө оруулалт энэ салбарт маш хангалтгүй байна. Түүнчлэн нийт ЖДБЭ-дийн 20% нь хоёр буюу түүнээс дээш санхүүгийн эх үүсвэрээр бизнесээ эхлүүлж байснаас өөрийн хөрөнгө ба банкны зээл, өөрийн болон гэр бүлийн хөрөнгөний холимог санхүүжилт хамгийн өндөр хувийг эзэлж байна. Зураг 17-г харна уу.


Зураг 17. ЖДБЭ-дийн анхны санхүүжилтийн эх үүсвэр



Цаашид мэргэжлийн санхүүгийн зуучлагч, зөвлөгөө өгөгчийн хувьд арилжааны банк, бүх төрлийн банкнаас бусад санхүүгийн байгууллагууд, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, гадаадын хөнгөлөлттэй зээлийн төслүүдээр энэ салбарт санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх шаардлага өндөр байна гэж бид үзлээ.

Монгол Улсын “Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай” хуульд тусгагдсан борлуулалтын орлогын ангилаллын дагуу авч үзвэл судалгаанд оролцсон нийт ЖДБЭ-дийн 86% нь орлогын түвшнээр “бичил бизнес”-ийн ангилалд хамаарч буй бол ердөө 10% нь жижиг, 4% нь дунд хэмжээний бизнест хамаарч байна. Зураг 18-г харна уу. Өмнөх Зураг 10-д үзүүлснээр ажилтны тооны хувьд нийт ЖДБЭ-дийн 78.9% нь “бичил” ангилалд хамаарч байсан бол борлуулалтын орлогын түвшнээр 86% нь уг ангилалд хамаарч буйг бодлого боловсруулагчид анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Зураг 18. ЖДБЭ-дийн жилийн борлуулалтын орлого



1.5.1. Санхүү, эдийн засгийн өрсөлдөх чадвар

Сүүлийн 18 сарын туршид буюу цар тахлын нөлөө улсын эдийн засагт сөргөөр мэдрэгдэж эхэлснээс хойш нийт ЖДБЭ-дийн 76%-ийнх нь борлуулалтын орлого бүүрчээ. Зураг 19-ыг үзнэ үү.

Зураг 19. Цар тахлын ЖДБЭ-дийн борлуулалтын орлогод үзүүлж буй нөлөө




Харин энэ хугацаанд 8%-ийнх нь орлого өссөн бол 16% нь өөрчлөлтгүй байна. Өөрөөр хэлбэл 4 компани тутмын 3 нь цар тахалд “өртөж” байна. Мөн 2 компани тутмын 1 нь 2020 онд алдагдалтай ажилласан бол 3 компани тутмын 1 нь л ашигтай ажиллажээ. Хэдийгээр нийт аж ахуйн нэгжүүдийн 76%-д нь борлуулалтын орлого бүүрсан боловч 53% нь 2020 онд ашигтай эсхүл баланслаж чадсан нь зарлагын таналтыг эдгээр аж ахуйн нэгжүүд сайн хийсэн байх талтай.

Сүүлийн 18 сарын туршид нийт ЖДБЭ-дийн 25% нь шинээр санхүүжилт авч чадсан бол 23% нь хүссэн ч эс авч чаджээ. Харин 2% нь хүлээлтийн байдалд байгаа бол 2 компани тутмын 1-д шинэ санхүүжилт шаардлагагүй байв. Шинээр босгосон санхүүжилтийн 75% нь банкны зээл бол өөрийн хөрөнгө болон ЖДҮ сангийн санхүүжилт 10% тус тус эзэлж байна. Зураг 22-ийг үзнэ үү.

Зураг 21. ЖДБЭ-дийн санхүүжилтийн хэрэгцээ


Зураг 22. ЖДБЭ-дийн санхүүжилтийн эх үүсвэр



Хэдийгээр бизнесийн гарааны санхүүжилтэд өөрийн болон гэр бүлийн хөрөнгө өндөр дүн эзэлж байсан боловч удаах санхүүжилтэд банкны салбарын зээл голлох байр


суурьтай харагдав. Нөгөө талаар Засгийн газраас цар тахалтай тэмцэх, эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хүрээнд хүү бага, хугацаа үрт зээлийн бүтээгдэхүүнүүдийг арилжааны банкуудаар дамжуулан олгож буй нь тодорхой хэмжээнд үр өгч байна. Гэвч нийт ЖДБЭ-дийн 23% нь шинээр санхүүжилт хүссэн боловч авч чадаагүй шалтгааныг нарийвчлан судалж үзлээ. Зураг 23-ыг үзнэ үү.

Зураг 23. Санхүүжилт авч чадаагүй үндсэн шалтгаанууд



Судалгаанд хамрагдсан 4 компани тутмын 1 нь барьцаа хөрөнгө дутмагаас болж зээл авч чадаагүй бол 18% нь зээлийн хүү өндөр байдаг гэж хариулсан. Мөн 17% нь хөрөнгийн үнэлгээ бодитой бус, 12% нь санхүүгийн байгууллагуудын зээлийн процесс удаан, чирэгдэл ихтэй гэж хариулсан бол 10% нь өөрийн тогтмол орлогоо баталгаажуулж чаддаггүй ажээ. Харин 25 компани тутмын ердөө 1 нь зээлийн хугацаа богино байдаг гэж хариулсан. Иймд бодлого боловсруулагчдын зүгээс зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг бодитоор дэмжих, зээлийн хүүг шат дараатай бууруулах шаардлагатай байхаас гадна хөрөнгийн үнэлгээний чадавхийг дээшлүүлэх, бодитоор үнэлэх ажлыг эрчимжүүлэх нь чухал байна. Мөн нийт асуудлуудын 51% нь банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай шууд холбогдож байна (18%, 17%, 12%, 4%).

Зураг 24. Зээл авахад барьцаалсан хөрөнгө




Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 60% нь зээл авахдаа эзэмшигчийн хувийн өмчийг барьцаалсан бол 34% нь байгууллагын нэр дээрх барилга болон газраа барьцаалжээ. Ердөө 4 компани “Зээлийн батлан даалтын сан”-гаар барьцаа хөрөнгөний батлан даалт гаргуулж чадсан бол 5 компани тутмын 1 нь 2 буюу түүнээс дээш хөрөнгө барьцаалсан байна (Зураг 24).

Сонирхолтой нь огт хөрөнгө барьцаалалгүйгээр 18 аж ахуйн нэгж зээл авч чадсан бол 9 жижиг, дунд бизнес эрхлэгч авлага, бараа материал барьцаалан зээл авсан байна. Банкны салбараас энэ төрлийн зээл гарахаа больсон тул ББСБ, ХЗХ-дод энэхүү практик үйлчилж байх боломжтой юм.

Нийт судалгаанд хамрагдагсдын 52% нь цар тахлын үед тулгамдаж буй санхүүгийн хамгийн том хүндрэл бол ажилчдын цалин, НДШ гэж хариулсан бол 48% нь НӨАТ, ААНОАТ, Гаалийн болон татварын зардал гэж үзэж байна. Сонирхолтой нь зээлийн төлбөрийн дарамт нийт судалгаанд хамрагдсан ЖДБЭ-дийн 30%-д үүссэн бол цахилгаан, ус, дулаан зэрэг тогтмол зардлууд 10 бизнес эрхлэгч тутмын 4-т нь дарамт болсоор байна. Зураг 25-ыг харна уу.

Санхүүгийн бус хүндрэлүүдийн хувьд ЖДБЭ-дийн бараг 70% нь цар тахал, хөл хорионы улмаас үйлдвэрлэл, үйлчилгээ, хүргэлт тасалдсан нь хамгийн том хүндрэл гэж дүгнэсэн. Мөн 10 компани тутмын 6 нь борлуулалт бүүрсан, 4 нь түүхий эд, материалын нийлүүлэлт доголдсон гэж үзэж байна. Мөн 16% нь бэлэн мөнгөний хомсдолд өртжээ (Зураг 26).

Зураг 25. Цар тахлын үед тулгамдаж буй санхүүгийн хүндрэлүүд




Зураг 26. Цар тахлын үед тулгамдаж буй бусад хүндрэлүүд



Компаниудын 23.7% нь цар тахлын улмаас орон тооны цомхотгол хийсэн гэж хариулсан бол 4 компани тутмын 3 нь цомхотгол хийгээгүй ажээ. Харин 1.6% хувь нь орон тоогоо өнгөрсөн хугацаанд нэмэгдүүлсэн байна. Эдгээр нь худалдаа, үл хөдлөхийн салбарт түлхүү хамаарч байна (Зураг 27). Цаашид хатуу хөл хорио дахин тогтоовол нийт бизнесийн 31% нь ердөө нэг сарын дотор дампуурах эрсдэлтэй байгаа бол 6 сар хүртэл хөл хорио тогтоовол 3 ЖДБЭ-дийн 2 нь дампуурах магадлалтай байна. Харин 11% нь хатуу хөл хорио үйл ажиллагаанд “нөлөөлөхгүй” гэж хариулсан (худалдаа, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбарууд). Зураг 28-ыг харна уу.

Зураг 27. Цар тахлаас улбаасан орон тооны цомхотгол




Зураг 28. Цар тахлаас тэсэн гарах чадамж



Монгол Улсын Засгийн газраас коронавирус цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөлтэй тэмцэх зорилгоор 2020 онд жижиг, дунд бизнесийн орчинд шууд хамааралтай 7 төрлийн багц арга хэмжээ хэрэгжүүлсэн билээ. Эдгээр арга хэмжээнүүдийн бодит нөлөөг нэг бүрчлэн судлан тооцох нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн цар тахлын үеийн өрсөлдөх чадамжид чухал ач холбогдолтой гэж үзсэн. Зураг 29-ийг үзнэ үү.

Судалгааны үр дүнгээс үзэхэд орлогын албан татварыг 6 сараар чөлөөлсөн шийдвэр нь ЖДБЭ-дийн 43%-д нь нөлөө үзүүлээгүй гэсэн бол мэдэхгүй гэж 13% нь хариулжээ (нийт 56%). Харин уг шийдвэр бизнест нь маш сайн, сайн нөлөөлсөн гэж судалгаанд оролцогсдын 33% хариулсан нь уг шийдвэр 3 бизнес эрхлэгч тутмын 1-д үр дүнгээ өгснийг илтгэнэ. Нийгмийн даатгалын шимтгэлийг 6 сараар чөлөөлсөн шийдвэр судалгаанд оролцогсдын 16%-иас маш сайн, 40%-иас сайн нөлөөлсөн гэсэн дүн авсан нь нийт ЖДБЭ-дийн 56%-ийг эзэлж буй нь “боломжийн” үр дүн үзүүлснийг харуулна.


Зураг 29. ЗГ-аас 2020 онд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр нөлөө (1)



Харамсалтай нь судалгаанд оролцсон жижиг, дунд бизнесийнхний 56% нь ажилчдад олгосон 200,000 төгрөгийн дэмжлэгийг огт нөлөөлөөгүй гэж хариулсан бол 11% нь энэ талаар мэдээгүй гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл 3 аж ахуйн нэгж тутмын 2 нь уг шийдвэрийн нөлөөг амсаагүй байна. Энэ нь жижиг, дунд бизнесийн салбарт албан бус хөдөлмөрлөлт ихтэй, зарим тохиолдолд үндсэн ажилтнаар ажилдаг ч НДШ-ээ цаг тухайд нь тогтмол төлөх боломж хомс байдагтай холбоотой гэсэн таамаглаж дэвшүүлж байна. Мөн түрээсийн төлбөрөө бүүруулсан бол уг дүнгээр нь төсвийн дэмжлэг олгох шийдвэр нийт ЖДБЭ-дийн 11 хувьд нь эерэгээр нөлөөлсөн бол 10 компани тутмын 9-д нь нөлөө үзүүлж чадсангүй.

Харин тогтмол зардлын төлбөрийг 100% чөлөөлсөн шийдвэр 3 жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 2-т нь маш сайн буюу сайнаар нөлөөлж чадсан нь байгаа оносон арга хэмжээ болжээ. Зураг 30-г харна уу. Харамсалтай нь цар тахлын сөрөг нөлөөг саармагжуулах зорилгоор зарим нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний импортын татварыг чөлөөлсөн шийдвэр нь энэ салбарт байгаа оносонгүй. Учир нь нийт судалгаанд оролцогсдын 63% нь энэ шийдвэр үйл ажиллагаанд нь нөлөөлөөгүй гэж хариулсан бол 30% мэдэхгүй буюу сөргөөр нөлөөлсөн гэж хариулжээ.

Зураг 30. ЗГ-аас 2020 онд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр нөлөө (2)




Мөн “лоозогнолтын” шинжтэй дахин нэг арга хэмжээ төлөвлөгдсөн нь төрийн худалдан авах үйл ажиллагаа буюу тендерт үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжсэн шийдвэр байв. Энэхүү шийдвэр нь бизнест нөлөөлөөгүй, сөргөөр нөлөөлсөн, мэдэхгүй гэж хариулсан оролцогсад нийт судалгаанд оролцогсдын 95%-ийг эзэлж байна. Ердөө 1% нь уг шийдвэрийг маш сайн, 2% нь сайнаар нөлөөлсөн гэж хариулсан нь дараах дүгнэлтэд хүргэж байна. Нэг бол “мөрөөдлийн” шинж чанартай ийм арга хэмжээг дахин

зарлахгүй байх, эсхүл уг арга хэмжээнд бодит гүйцэтгэл, үр дүн авчрах шаардлагатай нь харагдав. Засгийн газраас 2020 онд хэрэгжүүлсэн энэхүү чухал 7 багц арга хэмжээнээс жижиг, дунд бизнес эрхлэгчдэд ердөө 2 шийдвэр нь буюу “тогтмол зардлын төлбөрөөс чөлөөлсөн”, “НДШ-ийг 6 сараар чөлөөлсөн” нь зохих эерэг үр дүнг авчирсан бөгөөд **харамсалтай нь бусад 5 арга хэмжээ дорвитой үр дүнд хүрсэнгүй нь** цаашид төрийн бодлогын оновчтой байдлыг нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой болсныг сануулж байна.

Энэ оны турш төрөөс хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-нд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлэх боломжтой гэж тооцсон 9 арга хэмжээг сонгон авч үр дүнг мөн үнэлсэн. Зураг 31-ийг үзнэ үү.

Цогц төлөвлөгөөнд “Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд жилийн гурван хувийн хүүтэй, гурван жилийн хугацаатай хоёр их наяд төгрөгийн зээл олгох” арга хэмжээ батлагдсан. Энэ оны 3 дугаар улирлын байдлаар уг 3%-ийн хүүтэй зээл үйл ажиллагаанд нь маш сайн нөлөөлсөн гэж нийт ЖДБЭ-ийн 7%, сайн нөлөөлсөн гэж 15% хариулсан байна. Гэвч нөлөө үзүүлээгүй буюу мэдэхгүй гэж 10 бизнес эрхлэгч тутмын 7 нь хариулжээ.

Зураг 31. ЗГ-аас 2021 онд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр нөлөө (1)




Мөн ипотекийн 6%-ийн хүүтэй зээл жижиг, дунд бизнесийн салбарт ахицтай нөлөө үзүүлж чадаагүй бөгөөд нийт судалгаанд оролцогсдын 93% нь нөлөөлөөгүй болон мэдэхгүй гэж хариулсан байна. Энэхүү арга хэмжээ нь зорилтот салбарын хөтөлбөр шинжтэй тул судалгаанд оролцсон 124 барилгын компанийг тусгайлан сонгож хариултад

шинжилгээ хийж үзэхэд эдгээр барилгын компаниудын 96 хувь нь нөлөөлөөгүй болон мэдэхгүй гэж хариулсан нь харамсалтай. Түүнчлэн энэ хөтөлбөрийн дам нөлөө нь орон сууцны үнийг хөөрөгдөх эрсдэл дагуулж байна.

Төрөөс хэрэгжүүлж буй бодлогын 3 дахь арга хэмжээ болох “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, малчдын орлого, амьжиргааг дэмжих зорилгоор 500 тэрбум төгрөг төсөвлөсөн” нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд дэмжлэг болж чадаагүй байна. Нийт жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 95.4% нь энэ арга хэмжээ огт нөлөөлөөгүй буюу мэдэхгүй гэж хариулсан байна. Нарийвчлан авч үзвэл хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж буй 73 ЖДБЭ-дийн хувьд “ХАА салбарт хаврын тариалалт, ноос, арьс шир, малчдын хөнгөлөлттэй зээл” олгосон дэмжлэг нь ердөө 9 ЖДБЭ-дэд буюу энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн 12%-д л сайнаар нөлөөлсөн бол үлдсэн 88% нь тааруухан/нөлөөгүй/мэдэхгүй гэж хариулсан болно. Түүнчлэн бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх удаах хөтөлбөр нь мөн л тааруухан үр дүнтэй байгаа ба нийт судалгаанд оролцогсдын 84% нь нөлөөлөөгүй/сөргөөр нөлөөлсөн/мэдэхгүй гэсэн хариултуудыг сонгожээ. Ердөө 6% нь сайн, маш сайн нөлөө үзүүлсэн гэж дүгнэв.

Одоо хэрэгжиж буй зорилтот 9 хөтөлбөрөөс бизнес эрхлэгчдийн тогтмол зардлын төлбөрийг чөлөөлсөн арга хэмжээ ЖДБЭ-дэд хамгийн сайнаар нөлөөлж байна. Тодруулбал, нийт оролцогсдын 15% маш сайн, 44% сайн нөлөөлсөн гэж үзсэн бол нөлөөлөөгүй гэж 29% нь хариулжээ. Нийт ЖДБЭ-дийн 65%-д энэхүү арга хэмжээ ямар нэгэн байдлаар эерэг нөлөө үзүүлсэн (Зураг 32).


Зураг 32. ЗГ-аас одоо хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр нөлөө (2)



Мөн нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой хувийг чөлөөлсөн арга хэмжээг нийт судалгаанд оролцогсдын 4% нь маш сайн, 21% нь сайн, 9% нь тааруухан хэдий ч нөлөөлсөн гэж үзсэн нь 10 компани тутмын 3-т нь энэ арга хэмжээ зохих үр дүнгээ өгснийг илтгэж байна. Харамсалтай нь тендерт үндэсний болон ногоон үйлдвэрлэгчдийг дэмжих болон аж ахуйн нэгжүүдэд хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнүүд зорилтот зах зээлдээ хүрч амжилгүй замхран оджээ. Энэ хоёр арга хэмжээний талаар судалгаанд оролцсон 20 компани тутмын 19 нь нөлөөлөөгүй буюу мэдэхгүй гэж хариулсан.

Зураг 33-т үзүүлснээр “Зээлийн батлан даалтын сан”-гийн санхүүгийн чадавхийг нэмэх зорилгоор 50 тэрбум төгрөгийн өрийн хэрэгсэл гаргахыг зөвшөөрч дэмжсэн шийдвэр жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд бараг нөлөө үзүүлээгүй байна. Мөн л нийт судалгаанд оролцогсдын 95% нь энэ арга хэмжээ нөлөө үзүүлээгүй буюу мэдэхгүй гэж хариулсан нь анхаарал татна.

Зураг 33. ЗГ-аас 2021 онд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн үр нөлөө (3)




Дүгнэж үзэхэд Монгол Улсын Засгийн газраас одоо хэрэгжүүлж буй 9 арга хэмжээнээс зөвхөн 1 арга хэмжээ буюу “Тогтмол зардлын төлбөр чөлөөлсөн” шийдвэр ЖДБЭ-дийн 59%-ийн дэмжлэгийг авч чадаж байна. Мөн НДШ-ийн тодорхой хувийг чөлөөлсөн арга хэмжээ бизнес эрхлэгчдийн 30%-д хүрчээ. Харамсалтай нь бусад 7 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрч чадаагүй, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан, тунхаглалын шинжтэй болжээ. Учир нь судалгаанд оролцогчдын дунджаар 75% нь уг 7 арга хэмжээг “нөлөө үзүүлээгүй” гэж дүгнэж буй бол 20% нь “мэдэхгүй” гэж хариулжээ.

1.5.2. Ажиллах хүчний өрсөлдөх чадвар

Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд хөдөлмөрийн зах зээл дээрх ажиллах хүчний өрсөлдөөн томоохон корпорацитууд болон шинэ технологийн компаниудтай харьцуулахад хөнгөн бөгөөд боловсон хүчний нийлүүлэлт нь харьцангуй түгээмэл байдаг.

Зураг 34. Боловсон хүчний хангамж



Зураг 35. Боловсон хүчний үр чадвар


Судалгаанд хамрагдагсдын 51% нь ажилд орох сонирхолтой бөгөөд шаардлага хангасан боловсон хүчин хөдөлмөрийн зах зээл дээр “боломжийн” байдаг гэж үзсэн бол 14% хангалттай их гэж дүгнэжээ. Ердөө 10 бизнес эрхлэгчийн 3 нь л ажиллах хүчний нөөц хангалтгүй гэж хариулсан. Түүнчлэн удирдлагын 94% нь ажилчдынхаа үр чадварыг “маш сайн, сайн болон боломжийн” гэж хариулсан нь ЖДБЭ-дийн хувьд хөдөлмөрийн зах зээл дээр системийн шинжтэй хүндрэл үүсээгүй болохыг нотлоно. Боловсон хүчний хангамжийг бүс, нийслэлээр нарийвчлан Хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. Ажиллах хүчний хангамж (бүс, нийслэлээр)

№	Бүс	Аймаг	ААН Тоо	Хангалттай их	Боломжийн	Хангалтгүй	Мэдэхгүй
1	Баруун бүс	Баян-Өлгий	42	13%	47%	31%	8%
2		Ховд	53				
3		Увс	63				
4	Хангайн бүс	Завхан	34	16%	35%	41%	9%
5		Хөвсгөл	30				
6		Архангай	9				
7		Булган	24				
8		Сэлэнгэ	31				
9		Дархан-Уул	30				
10		Орхон	26				
11		Төв	13				
12	Алтайн бүс	Говь-Алтай	15	13%	36%	43%	8%
13		Өвөрхангай	28				
14		Баянхонгор	32				
15	Говийн бүс	Дорноговь	24	14%	47%	31%	8%
16		Дундговь	12				
17		Өмнөговь	51				
18		Говьсүмбэр	3				
19	Зүүн бүс	Хэнтий	13	15%	46%	37%	1%
20		Дорнод	34				
21		Сүхбаатар	20				
22		Улаанбаатар	958	14%	57%	24%	5%

Хүн ам ихээр төвлөрсөн, ажиллах хүчний хангамж харьцангуй сайтайн хувьд Улаанбаатар хотын жижиг, дунд бизнесүүдийн 71% нь боловсон хүчин “хангалттай их” болон “боломжийн” байдаг гэж хариулжээ. Харин Алтайн бүсийн хувьд нийт судалгаанд оролцогсдын 43% нь буюу хамгийн олон оролцогсад орон нутагт нь ажиллах хүчний хангамж “хангалтгүй” гэж хариулсан нь нийслэл хотоос бараг 20 нэгж хувиар өндөр байна. Сонирхолтой нь Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотууд оршдог Хангайн бүсэд нийт судалгаанд оролцогсдын 41% нь ажиллах хүчин хангалтгүй байдаг гэж хариулсан нь Алтайн бүсийг эс тооцвол бусад бүсүүдээс харьцангуй өндөр байна. Говийн болон баруун бүсийн хувьд оролцогсдын 31% нь ажиллах хүчин хангалтгүй гэж хариулсан нь 10 компани тутмын 3-т нь энэ бэрхшээл үүссэн болохыг харуулна.


Зураг 36. Боловсон хүчний хангамж (салбаруудаар)



Соёл урлаг, үзвэр үйлчилгээний салбарт ажиллаж буй ЖДБЭ-дийн 87.5%, эрүүл мэндийн салбарын 77.6%, уул уурхай болон үл хөдлөх хөрөнгийн салбарын 77%, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын 66% нь боловсон хүчний хангамж “хангалттай их” болон “боломжийн” байдаг гэж хариулсан. Харин мэдээлэл, харилцаа холбооны салбарын 47%, барилгын салбарын 40%, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 38%, хөдөө аж ахуйн салбарын 34% нь боловсон хүчин буюу ажиллах хүчний хангамж “хангалтгүй” байдаг гэж хариулсан нь сонирхол татаж байна.

Гэхдээ дотооддоо болон олон улсын түвшинд өрсөлдөх чадвараа сайжруулахын тулд ажилчдыг тогтмол давтан сургах нь чухал бөгөөд судалгаа, хөгжүүлэлтийн ажилд төсөв хөрөнгө зарцуулж шинэ боломжууд эрэлхийлж байх нь чухал билээ.

Зураг 37. Ажилчдыг давтан сургах хэрэгцээ, шаардлага ба судалгаа, хөгжүүлэлт



Өнгөрсөн нэг жилийн хугацаанд судалгаанд оролцсон ЖДБ-үүдийн 71% нь ажилтнуудаа сургалтад хамруулаагүй бол ердөө 20% нь ямар нэгэн сургалтад хамруулсан гэж хариулжээ. Цаашилбал, нийт оролцогсдын 8% нь ажилчдаа давтан сургах, сургалтад хамруулах шаардлагагүй гэж үзсэн байна. Мөн 4 компани тутмын 3 нь сүүлийн үед дангаараа эсхүл бусадтай хамтран судалгаа, хөгжүүлэлтийн ажил хийгээгүй гэж хариулсан байна. Эсрэгээрээ 14% нь бүтээгдэхүүн, үйлчилгээний судалгаа, хөгжүүлэлтийн ажил хийжээ. Дүгнэж үзвэл хэдийгээр цар тахлын нөлөө ЖДБЭ-дэд хүчтэй цохилт болж буй нь тодорхой ч тэдний “антпренер” сэтгэлээ, чадавхи хангалттай биш байна. Энэ нь тоног төхөөрөмжийн чанар, хангамжтай уялдсан эсэхийг нягтлая.


1.5.3. Тоног, төхөөрөмжийн болон антпренер өрсөлдөх чадвар

Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаандаа ашиглаж буй тоног төхөөрөмж нь шаардлага хангаж буй гэж 68% нь хариулсан бол тааруухан буюу хангахгүй байна гэж 30% үзжээ (Зураг 38). Сонирхолтой нь бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ нэр төрлийг олшруулж, чанарыг сайжруулахад тоног төхөөрөмжөө шинэчлэх шаардлагатай байна уу гэсэн асуултад нийт оролцогсдын бараг 80% тийм гэж хариулсан. Өөрөөр хэлбэл, тоног төхөөрөмж нь шаардлага хангаж буй гэж 10 оролцогсдын 7 нь хариулсан боловч инноваци хийхэд тоног төхөөрөмжөө шинэчлэх шаардлагатай гэж 5 оролцогчийн 4 нь үзсэн. Иймд жижиг, дунд бизнесийн салбарт технологийн шинэчлэл хийх асуудлыг хэрэгцээ болон хүчин чадалд нь тулгуурлаж гүнзгийрүүлэн судлах шаардлагатай нь харагдаж байна.

Оролцогсодын 75% нь сүүлийн нэг жилийн хугацаанд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлээгүй гэж хариулсан бол шаардлагагүй гэж 8%, нэвтрүүлсэн гэж 16% нь хариулжээ. Тодруулбал сүүлийн нэг жилийн хугацаанд дангаараа болон бусадтай хамтран судалгаа, хөгжүүлэлтийн ажил хийсэн ЖДБЭ-дийн 46% нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж чадсан бол судалгаа, хөгжүүлэлтийн ажил хийгээгүй аж ахуйн нэгжүүдийн 13% нь шинэ, бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлжээ. Мөн шаардлага байгаагүй гэж хариулсан бизнес эрхлэгчдийн ердөө 9% нь шинэ, бүтээгдэхүүн үйлчилгээ санаачилсан байна. Эндээс үзвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний судалгаа, хөгжүүлэлтийн ажилд хөрөнгө зарцуулах нь шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх чадавхийг энэ чиглэлд хөрөнгө зарцуулдаггүй компаниудтай харьцуулахад бараг 4


дахин, шаардлага байхгүй гэж үзсэн компаниудтай харьцуулахад 5 дахин нэмэгдүүлдэг байна.

Зураг 38. ЖДБЭ-дийн тоног төхөөрөмжийн хангамж, антпренер чадавхи ба инноваци




Түүнчлэн ЖДБЭ-дийн 32% нь ойрын ирээдүйд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх боломж ихтэй гэж хариулсан бол, 35% нь тааруухан, 13% шаардлагагүй, 11% нь боломжгүй, 9% нь мэдэхгүй байна гэж хариулжээ. Нягталбал сүүлийн нэг жилийн хугацаанд дангаараа болон бусадтай хамтран судалгаа, хөгжүүлэлтийн ажил хийсэн ЖДБЭ-дийн 51% нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх боломж ихтэй гэж хариулсан бол судалгаа, хөгжүүлэлтийн ажил хийгээгүй аж ахуйн нэгжүүдийн 41% нь, шаардлагагүй гэж хариулсан бизнесменүүдийн 21% мөн боломж ихтэй гэж өөдрөг хариулт өгсөн. Эндээс дүгнэхэд бүтээгдэхүүн, үйлчилгээний судалгаа, хөгжүүлэлтийн ажилд хөрөнгө зарцуулдаг аж ахуйн нэгжүүдийн ирээдүйн инновацлаг хүлээлт нь бусад компаниудтай харьцуулахад 10-30 нэгж хувиар өндөр байна.

Зураг 39. Тоног төхөөрөмжийн хангамж (зарим салбаруудаар)



Уул уурхай, эрүүл мэнд, мэдээлэл, харилцаа холбоо, боловсруулах үйлдвэрлэл зэрэг харьцангуй биет капиталын оролцоо өндөртэй салбаруудад тоног төхөөрөмж хангалттай бий гэж ихэнхи жижиг, дунд бизнес эрхлэгчид хариулсан. Харамсалтай нь улсын эдийн засгийн тулгуур салбаруудын нэг хөдөө аж ахуйн салбарт тоног төхөөрөмжийн хангамж “тааруухан” гэж оролцогсдын 42%, “хангалтгүй” гэж 10% нь хариулсан нь анхаарал татав. Мөн барилга болон боловсрол, шинжлэх ухааны салбарын тоног төхөөрөмж “хангалтгүй” гэж хариулсан ЖДҮ бусад салбаруудаас дунджаар 3 нэгж хувиар өндөр байна.

Зураг 40. Шинэ бүтээгдэхүүн/үйлчилгээ нэвтрүүлсэн эсэх (салбаруудаар)



Зураг 40-д шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ сүүлийн нэг жилийн хугацаанд нэвтрүүлсэн эсэхийг эдийн засгийн салбараар ангилан харуулав. Мэдээлэл, харилцаа холбоо болон урлаг, үзвэрийн салбар харьцангуй инновацлаг буюу 3 компани тутмын 1 нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж чадсан бол тээвэр, аялал жуулчлал, боловсрол, барилга, хөдөө аж ахуйн салбаруудын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх чадамж сүүлийн нэг жилийн хугацаанд мүү байжээ.

Цар тахлыг хязгаарлан барих зорилгоор хэрэгжүүлсэн хэд хэдэн удаагийн хатуу хөл хорио ЖДБЭ-дийн үйл ажиллагааны хүчин чадалд хэрхэн нөлөөлснийг Зураг №37-д үзүүлэв. Цар тахал, хатуу хөл хорионы улмаас өнгөрсөн нэг жилийн хугацаанд ЖДБЭ-дийн 61% хувь нийт хүчин чадлынхаа 50 хүрэхгүй хувийг ашиглажээ. Ердөө 16% нь хүчин чадлынхаа ихэнхи хувийг ашигласан байна. Харин 1% нь хүчин чадлаа давуулан ашигласан буюу шинээр хүчин чадлаа нэмэгдүүлсэн гэж хариулсныг нягтлан үзэхэд эрүүл мэнд, худалдааны салбарын аж ахуйн нэгжүүд зонхилох хувийг эзлэж байв.

Зураг 41. Хүчин чадлын ашиглалт болон дотоодын ханган нийлүүлэлт



Бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлэхэд дотоодын нөөц, түүхий эдээ бүрэн ашигладаг гэж 5 компани тутмын 1 нь хариулсан бол 10 компани тутмын 6 нь орцынхоо ердөө 50 хүртэлх хувийг дотоодын түүхий эд, нөөцөөр хангадаг байна. Өөрөөр хэлбэл цаашид цар тахал болон аливаа улс төр, эдийн засгийн шалтгаанаар хоёр хил хаагдах нөхцөлд нийт жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 80%-д нь үйл ажиллагааны доголдол үүсч түүний 75% нь богино хугацаанд түүхий эд, орцын гачигдалд өртөх эрсдэлтэй байна. Иймд төрийн зүгээс дотоодын аж ахуйн нэгжүүдийн нийлүүлэлтийн гинжин хэлхээг илүү боловсронгуй, үр ашигтай болгох, дотооддоо импортын орц, түүхий эдийг орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх чухал шаардлагатай байна.

1.5.4. Макро эдийн засгийн өрсөлдөх чадвар

Бүх шатны бизнесийн байгууллагуудын өрсөлдөх чадварт улсын макро эдийн засгийн нөхцөл байдал, үндсэн үзүүлэлтүүд хүчтэй нөлөө үзүүлдэг. Онолын хувьд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдээс дор дурдсан 5 үзүүлэлт байгууллагын өрсөлдөх чадварт хамгийн их нөлөөтэй гэж үздэг². Үүнд:

- 1) Эдийн засгийн өсөлт
- 2) Инфляци
- 3) Валютын ханш
- 4) Гадаадын хөрөнгө оруулалтын түвшин
- 5) Төв банкны гадаад валютын албан нөөц


Судалгааны асуулгын дизайныг боловсруулж, хяналтын судалгааг цөөн жижиг, дунд бизнес эрхлэгчдээс авах явцад төв банкны гадаад валютын албан нөөц жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд нөлөөлдөггүй болох нь батлагдсан бөгөөд дийлэнх оролцогсад “мэдэхгүй” гэж хариулсан тул бусад 4 хүчин зүйлээр нарийвчилсан судалгааг авсан болно. Зураг 42, 43-ийг үзнэ үү.

² Bekeris R. (2012) “THE IMPACT OF MACROECONOMIC INDICATORS UPON SME’S PROFITABILITY”, Ekonomika, 91(3), pp. 117-128.

Макро эдийн засаг ЖДБЭ-ийн үйл ажиллагаанд нөлөөлөх нь (1)

Зураг 42. Эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал

Зураг 43. Инфляци




Улсын эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал ЖДБЭ-дэд хэрхэн нөлөөлж буй талаар лавлахад оролцогсдын ердөө 2.2% маш сайн болон сайнаар нөлөөлж байна гэж хариулсан. Харин 60% нь муугаар нөлөөлж байна гэж хариулсан бол 30% маш муу нөлөөлж байна гэв. Өөрөөр хэлбэл 10 компани тутмын 9-д нь сүүлийн үеийн эдийн засгийн байдал муу, маш муу нөлөөлжээ. Сонирхолтой нь нийт судалгаанд оролцсон компаниудын 6.2% буюу 96 жижиг, дунд бизнес эрхлэгч эдийн засгийн нөхцөл байдал тэдний үйл ажиллагаанд нөлөөлдөггүй гэж хариулсан.

Цар тахлын улмаас иргэдийн худалдан авах чадвар буурсан, тансаг зэрэглэлийн бүтээгдэхүүнүүдийн арилжаа багассан, эрэлт ерөнхийдөө буурсан зэрэг шалтгаануудын улмаас манай улсын инфляцийн түвшин 2020 онд сүүлийн жилүүдэд байгаагүй доод түвшинд очсон боловч жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд үнийн өсөлт буюу инфляцийн түвшин муугаар нөлөөлж байна гэж 45.8%, маш муугаар нөлөөлж байна гэж 47.7% нь хариулсан. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцсон 20 компани тутмын 19-д нь инфляцийн дарамт хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байна. Харин төгрөгийн ханш үйл ажиллагаанд нь нөлөө үзүүлдэггүй гэж 65 компани хариулсан нь нийт оролцогсдын 4.2%-ийг эзэлж байна.

Макро эдийн засаг ЖДБЭ-ийн үйл ажиллагаанд нөлөөлөх нь (2)

Зураг 44. Төгрөгийн ханш

Зураг 45. Гадаадын хөрөнгө оруулалт



Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн ханш ам.доллар болон юаны эсрэг сулрах нь бизнес эрхлэгчдийн 43%-д муугаар 38.1%-д маш муугаар нөлөөлж байна гэжээ. Өөрөөр

хэлбэл судалгаанд оролцогсдын 81.1% нь төгрөгийн ханшийн сулралд гүн өртөмтгий байна. Учир нь өмнөх судалгаанд үзүүлсэнчлэн нийт ЖДБЭ-дийн 70% нь түүхийн эд, орцынхоо 26-100 хүртэлх хувийг импортын бүтээгдэхүүн, нөөцөөр хангадаг билээ. Зураг 44-ийг харна уу.

Гадаадын хөрөнгө оруулалт жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд нөлөөлдөггүй гэж оролцогсдын 34.3% буюу 3 компани тутмын 1 нь хариулсан нь сонирхол татаж байна. Харин маш сайн/сайн гэж ердөө 6.2% нь хариулсан бол муу/маш муу гэж 17.6% нь үзжээ. Өөрөөр хэлбэл гадны хөрөнгө оруулалтаас үр шим хүртсэн аж ахуйн нэгжийн тоо түүнд дургүй аж ахуйн нэгжүүдийн тооноос бараг 3 дахин бага байна. Зураг 43-ыг харна уу.

Мөн гадаадын хөрөнгө оруулалт үйл ажиллагаанд нь нөлөөлдөг эсэхэд мэдэхгүй гэж хариулсан хувь маш өндөр буюу 42% байгааг анхаарч үзэх нь чухал байна. Иймд цаашид гадаадын хөрөнгө оруулалтын үр шимийн талаар сурталчлан таниулах, түүнийг төрийн бодлогоор дэмжих, тогтвортой байдлыг нь хангаж өгөх нь төрийн хувьд чухал сорилт болжээ гэж бид үзэж байна.

1.5.5. Экспортын өрсөлдөх чадвар, саад бэрхшээлүүд


Энэ хэсэгт дотоодын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн дунд экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргадаг аж ахуйн нэгжүүдийг тодруулах, экспортын орлогын эзлэх хувь болон тэдгээр компаниудад гадаад худалдааны (экспорт, импортын) ямар хүндрэл бэрхшээлүүд үүсдэг талаар судлахыг зорьсон.

Судалгаанд оролцсон нийт ЖДБЭ-дийн ердөө 4% хувь буюу 58 компани бүтээгдэхүүн, үйлчилгээгээ экспортлодог гэж хариулсан бөгөөд үлдэх 1487 компани зөвхөн дотоодод бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулдаг аж. Зураг 46-г харна уу.


Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортлодог 10 компани тутмын 4 нь бүтээгдэхүүнийхээ талаас дээш хувийг экспортод гаргадаг бол бүтээгдэхүүнээ 100% гадагш нь борлуулдаг 15 компани энэхүү судалгаанд оролцжээ. Түүнчлэн бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ 25 хүртэлх хувийг экспортлодог 18 компани, 26-50%-ийг экспортлодог 15 компани байна. Зураг 47-г үзнэ үү.

ЖДБЭ-ийн экспортлох чадавхи түүний хүртээмж

Зураг 46. Бүтээгдэхүүн, үйлчилгээгээ экспортлодог эсэх




Зураг 47. Нийт борлуулалтын орлогод эзлэх экспортын орлогын хувь




Экспортод бүтээгдэхүүнээ гаргадаг эдгээр 58 компаниас экспорт хийх явцад тулгарч буй үндсэн хүндрэлүүдийг тодруулсан. Эдгээр компаниудын бараг 20% нь цар тахал, 17.8% нь худалдан авагч орны импортын татвар өндөр, 10.8% нь хил гаалийн ажилтнуудын хүнд суртал, 9.6% нь экспортлогчдод төрийн дэмжлэг сул байдаг нь хамгийн том бэрхшээлүүд гэж үзсэн. Мөн судалгаанд оролцсон 9 компани худалдан авагч орны импортын бүтээгдэхүүнд тавьдаг стандарт өндөр гэж хариулсан (Зураг 48).

Бүтээгдэхүүн экспортлох болон импортлоход тулгарч буй хүндрэлүүд
Зураг 48. Бүтээгдэхүүн экспортлоход тулгарч буй үндсэн хүндрэлүүд



Бүтээгдэхүүн импортлоход тулгарч буй үндсэн хүндрэлүүд
Зураг 49. Бүтээгдэхүүн импортлоход тулгарч буй үндсэн хүндрэлүүд



Мөн импортын татвар өндөр гэж 7%, Монгол Улсын Элчин сайдын яам, консулын газрын дэмжлэг сул гэж 7%, төгрөгийн ханшийн хэлбэлзэл гэж 7%, экспортын тусгайлсан санхүүжилт дутмаг гэж 5.1% нь хариулсан бол бусад хүндрэлүүд нийлээд 10.2%-ийг эзлэж байна. Иймд Монгол төрийн зүгээс өндөр импортын татвар ногдуулдаг гадаад худалдааны түншүүдтэйгээ тусгайлсан хэлэлцээр хийх, татварыг нь бууруулах, бизнес эрхлэгчдийн хувьд экспортын бүтээгдэхүүнийхээ стандарт, чанарыг олон улсын түвшинд хүргэх тус тус шаардлагатай байна.

Харин бүтээгдэхүүн импортлогчдын хувьд судалгаанд оролцсон 5 компани тутмын 1 нь санал нэгтгэйгээр манай улсын гааль, НӨАТ өндөр, хил гаалийн зохион байгуулалт муу, техник хангамж хоцрогдсон, хүнд суртал-авилгал ихтэй гэж хариулсан. Мөн дотоодын тээвэр зүүчийн компаниудын дунд өрсөлдөөн бага, үнэ өндөр гэж 16.7%, төгрөгийн ханшийн хэлбэлзэл гэж 11.4%, гадаад төлбөр тооцоо үнэтэй, хугацаа алддаг гэж 7.4%, импортын санхүүжилтийн хүрэлцээ дутмаг гэж 5.6% нь тус тус хариулсан. Оролцогч хамгийн чухал гэж үзсэн 5 хүртэлх хариулт сонгон хариулах боломжтой байсан тул нийлбэр хариулт 100%-иас илүү гарсан. Зураг 49-г харна уу.

Хүснэгт 3. Борлуулалтын орлого ба ашигт ажиллагаа (экспорт, экспортын бусаар)

	Борлуулалтын орлого			Ашигт ажиллагаа		
	Өссөн	Буурсан	Хэвэндээ	Ашигтай	Алдагдалтай	Балансласан
Экспортлогч ЖДҮ	10%	76%	14%	36%	48%	16%
Бусад ЖДҮ	8%	76%	16%	32%	47%	21%


Коронавирус цар тахлын улмаас үүссэн хүндрэлүүд нь борлуулалтын орлого хийгээд ашигт ажиллагаанд хэрхэн нөлөөлсөн талаар экспортлогч ЖДБЭ болон бусад ЖБДЭ-дийн хувьд ангилан тооцсон бөгөөд ингэхэд борлуулалтын орлого нь экспортлогчдын хувьд бусад ЖДБЭ-дээс 2 нэгж хувь, ашигт ажиллагаа нь 4 нэгж хувиар тус тус өндөр байна. Энэ нь экспортлогчдын хувьд орлогын эх үүсвэр нь ханшийн уналтаас хамгаалагдсан, олон улсын зах зээлд буюу илүү эрэлттэй сегментэд хүрч чадсан зэргээр тайлбарлагдаж болох юм. Гэхдээ уг зөрүү тун ялимгүй бага байгааг анзаарах нь зүйтэй бөгөөд энэ нь цар тахал дэлхий нийтийг хамарсан шинжтэй, нийлүүлэлтийн олон улсын гинжин хэлхээ бүхэлдээ хямарсан, олон улсын тээвэр зүүчийн үйл ажиллагаа хязгаарлагдсан зэргээр илэрхийлэгдэж болно гэж бид үзэж байна.

1.5.6. Дэд бүтцийн салбарын өрсөлдөх чадвар, бэрхшээлүүд


Манай улсын газар нутаг өргөн уудамтай холбоотойгоор даган гарах дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалт ихээхэн анхаарал татдаг. Иймд орон нутгаар тархан үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд бизнесүүдийг сонгон авч тэдэнд тулгарч буй дэд бүтцийн салбарын бэрхшээлүүдийг танин мэдэх нь энэ хэсгийн зорилт юм.

Гэхдээ үүний өмнө цар тахлын улмаас үүссэн хил, гаалийн хорио цээрийн дэглэм болон Замын-Үүд, Алтанбулаг боомтууд дахь бараа бүтээгдэхүүний бөөгнөрөл, хоцрогдол нь ЖДБЭ-дэд хэрхэн нөлөөлж буйг судлан үзлээ. Доорх зурагнаас харна уу.

Зураг 50. Замын-Үүд, Алтанбулаг боомтуудын нөхцөл байдал



Зураг 51. Дэд бүтцийн салбарын бэрхшээлүүд



Сүүлийн саруудад даамжран үргэлжилж буй Замын-Үүд, Алтанбулаг боомтууд дээр үүсээд буй ачаа, тээврийн саатал, түүнийг дагасан хүнд суртал, өртөг зардлын өсөлт судалгаанд оролцсон нийт бизнес эрхлэгчдийн 71.4%-д “мүү” болон “маш муугаар”

нөлөөлж байна. Харин нөлөөлөөгүй гэж нийт оролцогчдын 23.6% нь хариулсан. Иймд манай улсын хувьд хилийн боомтуудын хорио цээрийн дэглэмийн стандартыг боомтын ачаалал, багтаамж, ажиллах чадвартай нь уялдуулан дорвитой шинэчлэх шаарлагатай болсныг харуулж байна.

Дэд бүтцийн салбарын хувьд манай улсын жижиг, дунд бизнес эрхлэгчдэд тулгарч буй дэд бүтцийн салбарын бэрхшээлүүдээс “орон нутгийн зам”, “дулаан болон усан хангамж”-ийн систем хамгийн ноцтой нь байна. Учир нь оролцогчдын 31% нь орон нутгийн зам хамгийн хүнд дэд бүтцийн бэрхшээл гэж үзсэн бол 12% нь дулааны шугам сүлжээг нэрлэжээ. Улаанбаатар хотод байрлалтай жижиг, дунд бизнесийн байгууллагуудыг дэд олонлогоос хасч зөвхөн хөдөө орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг жижиг, дунд бизнесүүдийн хувьд дэд бүтцийн нөхцөл байдал илүү хүнд байна. Хүснэгт 4-г үзнэ үү.

Хүснэгт 4. УБ хот, орон нутгийн дэд бүтцийн салбар дахь бэрхшээлүүд

№	Бүс	Аймаг	ААН Тоо	Орон нутгийн зам	Олон улсын зам	Дулаан хангамж	Ус хангамж	Харилц аа холбоо
1	Баруун бүс	Баян-Өлгий	42	32%	14%	3%	6%	7%
2		Ховд	53					
3		Увс	63					
4	Хангайн бүс	Завхан	34	52%	13%	16%	11%	10%
5		Хөвсгөл	30					
6		Архангай	9					
7		Булган	24					
8		Сэлэнгэ	31					
9		Дархан-Уул	30					
10		Орхон	26					
11		Төв	13					
12	Алтайн бүс	Говь-Алтай	15	67%	8%	21%	11%	1%
13		Өвөрхангай	28					
14		Баянхонгор	32					
15	Говийн бүс	Дорноговь	24	47%	13%	3%	3%	0%
16		Дундговь	12					
17		Өмнөговь	51					
18		Говьсүмбэр	3					
19	Зүүн бүс	Хэнтий	13	51%	15%	1%	1%	1%
20		Дорнод	34					
21		Сүхбаатар	20					
22		Улаанбаатар	958	14%	26%	13%	13%	13%


Орон нутгийн замын сүлжээ Алтайн бүсийн аймгуудад (Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор) хамгийн хүндрэлтэй буюу тус аймгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 67% нь зам харгүй дэд бүтцийн хамгийн том бэрхшээл гэж үзэж байна. Хангайн бүсийн 52%, зүүн бүсийн 51%, говийн бүсийн 47% нь орон нутгийн зам дэд бүтцийн бэрхшээл үүсгэж байна гэж хариулсан. Сонирхолтой нь баруун бүсийн буюу Увс, Ховд, Баян-Өлгий аймгуудын хувьд орон нутгийн зам төдийлэн бэрхшээл үүсгэдэггүй ажээ.

Улаанбаатар хотын хувьд олон улсын шинж чанартай зам дутмаг нь дэд бүтцийн бэрхшээл үүсгэдэг гэж судалгаанд оролцогсдын 26% нь үзсэн хотын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд хамгийн хүнд дэд бүтцийн бэрхшээл ажээ. Дулаан болон ус хангамжийн хувьд Алтайн болон Хангайн бүсийн аймгуудад учирч буй бэрхшээл нь бусад бүсийн аймгуудаас 3-7 дахин илүү хүндрэл учруулж байна. Бас нэгэн сонирхолтой бэрхшээл Улаанбаатар хотын бизнест үүссэн нь мэдээлэл, харилцаа холбооны хүндрэл нийт жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн 13%-д нь тохиолдож байна. Энэ нь бусад бүх аймгуудтай харьцуулахад хамгийн өндөр хувь юм.

1.5.7. Жижиг, дунд бизнесийн салбарын хүндрэл, боломжит шийдлүүд

Энэ хэсэгт манай улсын жижиг, дунд бизнес эрхлэгчдэд тохиолдож буй борлуулалтын бэрхшээлүүдийг нарийвчлан авч үзсэн (Зураг 52). Түүнчлэн төрийн зүгээс жижиг, дунд бизнесийн салбарыг дэмжихэд “чухал шаардлагатай” гэж үзсэн арга хэмжээнүүдийг эрэмблэн тодруулав.

Зураг 52. Бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулахад үүсч буй хүндрэл бэрхшээлүүд



Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд бүтээгдэхүүнээ борлуулахад үүсч буй хамгийн том бэрхшээл нь коронавирусын тархалтын улмаас тавьсан хөл хорио болж байна (83.9%). Үүний дараа судалгаанд оролцогчдын 34.4% нь орон нутгийн худалдан авах чадвар сул, 13.8% нь дотоодын тээврийн сүлжээ хөгжөөгүй, 12.8% нь стандартын агуулах, зоорь хангалтгүй, 12.3% нь худалдан авагч тал монополь шинжтэй гэж хариулсан бол 5.9% нь нийлүүлэлтийн шаталсан (гинжин) бүтэц муу хөгжсөн гэж үзжээ. Мөн 25 компани тутмын 1 нь хэрэглэгчээсээ хол байрласан нь хүндрэлтэй гэж хариулсан байна.

Хүснэгт 5. УБ хот, орон нутгийн ЖДБЭ-дэд тулгарч буй борлуулалтын бэрхшээлүүд

№	Бүс	Аймаг	Хөл хорио	Худалдан авах чадвар	Дотоодын тээвэр	Агуулах, зоорь	Монополь худалдан авагч	Нийлүүлэлтийн гинжин бүтэц	Хэрэглэгчээс хол байрласан
1	Баруун бүс	Баян-Өлгий	91.1%	35.4%	12.7%	5.7%	4.4%	0.6%	5.7%
2		Ховд							
3		Увс							
4	Хангайн бүс	Завхан	69.0%	56.9%	23.4%	9.1%	6.6%	7.1%	6.6%

5		Хөвсгөл							
6		Архангай							
7		Булган							
8		Сэлэнгэ							
9		Дархан-Уул							
10		Орхон							
11		Төв							
12	Алтайн бүс	Говь-Алтай	89.3%	58.7%	12.0%	10.7%	0.0%	10.7%	8.0%
13		Өвөрхангай							
14		Баянхонгор							
15	Говийн бүс	Дорноговь	93.3%	25.6%	5.6%	1.1%	7.8%	2.2%	2.2%
16		Дундговь							
17		Өмнөговь							
18	Говьсүмбэр								
19	Зүүн бүс	Хэнтий	91.0%	34.3%	7.5%	9.0%	1.5%	0.0%	4.5%
20		Дорнод							
21		Сүхбаатар							
22		Улаанбаатар	83.9%	29.1%	13.4%	16.4%	16.9%	6.9%	3.0%

Хүснэгт 5-аас үзэхэд цар тахлын үлмаас тавьсан хөл хорио Хангайн бүсэд бусад бүсүүдтэй харьцуулахад арай бага сөрөг нөлөө үзүүлсэн байна (69%). Гэвч Алтайн болон Хангайн бүсүүдэд орон нутгийн худалдан авах чадвар хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байна (58.7%, 56.9%). Мөн Хангайн бүсийн 4 компани тутмын 1-д нь дотоодын тээврийн сүлжээ хөгжөөгүй нь бэрхшээл болж байгаа нь Баруун болон Говийн бүстэй харьцуулахад тун өндөр байна. Газар тариалангийн гол бүс нутаг болох Хангайн бүсэд стандартын агуулах, зоорь хангалтгүй байгаа нь хүндрэл учруулж байна гэж судалгаанд оролцогсдын 9.1% нь хариулсан. Сонирхолтой нь дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн Улаанбаатар хотын ЖДБЭ-дийн хувьд дотоодын тээврийн сүлжээ болон стандартын агуулах зоорь хангалттай хөгжөөгүй нь бэрхшээл дагуулахын зэрэгцээ худалдан авагч тал нь “монополь” шинжтэй байдаг гэж судалгаанд оролцогсдын 16.9% нь хариулжээ.

Судалгаанд оролцсон нийт 1545 жижиг, дунд бизнес эрхлэгчдээс тус салбарыг дэмжихэд шаардлагатай арга хэмжээнүүдийг сонгоно уу хэмээн 5 хүртэлх хариулт сонгох боломж өгсөн. Үүний хүрээнд нийт 4630 хариулт ирсэн нь нэг ЖДБЭ дунджаар 3 хариулт өгсөн гэсэн үг юм. Хүснэгт 6-аас дэлгэрэнгүй харна үү.

Хүснэгт 6. ЖДБЭ-ийг дэмжихэд зориулсан арга хэмжээнүүдийн эрэмбэлэлт

№	ЖДБЭ-ийг дэмжихэд ШААРДАГДАХ арга хэмжээнүүд	Хувь	Саналын тоо
1	Хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх	45.2%	699
2	Татварын таатай орчин бүрдүүлэх	42.7%	660
3	Төрийн үйлчилгээний хүнд суртлыг арилгах	30.4%	469
4	Авлигыг арилгах	25.3%	391
5	Хууль, эрх зүйн орчныг сайжруулах	24.3%	376
6	ЖБД-д зориулсан сургалт, зөвлөгөөг нэмэгдүүлэх	21.0%	325
7	Бизнестэй холбоотой төрийн шийдвэрт хувийн хэвшил, олон нийтийн оролцоог нэмэх	17.8%	275
8	Төрийн хяналт, шалгалтын тоог бууруулах	15.0%	232
9	Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг санаачлагч ЖДБ-ийг тусгайлан дэмжих	14.6%	225

10	Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих	13.9%	215
11	Зөвшөөрөл, лицензийн тоог багасгах	13.3%	206
12	ЖБД-ийг дэмжих, бойжуулах инкубатор төвүүд байгуулах	12.6%	194
13	Дэд бүцтийг сайжруулах	12.0%	185
14	Хөдөлмөрийн харилцааг (ажил олгогч-ажилтан) боловсронгуй болгох	11.5%	178
	Нийт	299.7%	4630

Оролцогчдоос хамгийн өндөр санал авсан 14 арга хэмжээнээс жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт **“Хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх”** арга хэмжээг нийт оролцогчдын 45.2% нь дэмжсэн байна. Энэ төрлийн санхүүжилтэд зөвхөн дотоодын бус гадны ялангуяа нэг талт түнш улс болон байгууллага, олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагуудаас олгодог төрөл бүрийн хөнгөлөлттэй санхүүжилтийн бүх эх үүсвэрүүд багтана. Нөгөө талаас өмнөх судалгаанд харуулсанчлан жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 51 хувьд нь санхүүжилтийн сайн эх үүсвэр шаардлагатай байгаа нь зүй тогтлын хувьд давхар баталгаажиг байх бөгөөд энэ арга хэмжээг төр, хувийн хэвшил хамтран гүйцэтгэх учиртай.

“Татварын таатай орчин бүрдүүлэх” нь энэ салбарт төрөөс үзүүлэх маш чухал дэмжлэг болохыг судалгаанд оролцогчдын 42.7% нь батлав. Иймд ЖДБ-ийн салбарт татварын төрөл бүрийн хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшуулал олгож бизнесийн эко орчныг дэмжих шаардлагатай байна. Мөн бодлого боловсруулагчдын зүгээс **“төрийн үйлчилгээний хүнд суртлыг арилгах”** арга хэмжээ авах нь энэ салбарыг урт хугацаанд, тогтвортой дэмжих удаах бодлогын арга хэмжээ болж байна (30.4%).

Мөн **“авилгалыг арилгах”** арга хэмжээ нь жижиг, дунд бизнесийн салбарт чухал нөлөөтэй болох нь судалгаанд оролцогчдын 25.3% нь дэмжсэнээс харагдаж байна. Энэ арга хэмжээг төр, хувийн хэвшил хамтран гүйцэтгэвэл илүү үр дүнд хүрэх болов уу. Цаашилбал уг салбарын үйл ажиллагааг зохицуулж буй **“хууль, эрх зүйн орчныг сайжруулах”**, бизнес эрхлэгчдэд илүү таатай болгох нь манай улсын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварт тун сайнаар нөлөөлөх нь гарцаагүй байна (24.3%).

Сонирхолтой нь төрөөс олгодог “зөвшөөрөл лицензийн тоог багасгах”, тус салбарыг дэмжих “инкубатор төвүүд байгуулах”, “дэд бүтцийг сайжруулах” болон ажил олгогч, ажилтны хоорондох “хөдөлмөрийн харилцааг боловсронгуй болгох” зэрэг асуудлууд харьцангуй дарамт багатай буюу хамгийн ард эрэмбэлэгджээ (бүгд 13.3%-иас бага дүн авсан).

1.6. НӨХЦӨЛТ СУДАЛГААНЫ НАРИЙВЧИЛСАН ҮР ДҮНГҮҮД

Таамаглал №1: Цар тахлын үед эмэгтэй захиралтай жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагууд илүү эмзэг болсон уу?

Тайлбар: Азийн хөгжлийн банкнаас Зүүн өмнөд Азийн орнуудын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн дунд хийсэн 2020 оны судалгаагаар Индонез, Малайз зэрэг улсуудад эмэгтэй захиралтай жижиг, дунд бизнесийн компаниуд эрэгтэй захиралтай компаниудтай харьцуулахад цар тахлын сөрөг нөлөөгөөр санхүүгийн хүндрэлд орох эрсдэл нь 10 нэгж хувиар өндөр байгааг харуулсан. Иймд манай улсын ЖДБЭ-дэд энэ төрлийн хүндрэл үүсч буй эсэхийг нягтлав. Хүснэгт 7-г үзнэ үү.

Хүснэгт 7. Цар тахлын үед эмэгтэй, эрэгтэй захирлуудад ажлын ялгаа гарсан уу?

Борлуулалтын орлого	Эр	Эм	Шинэ бүтээгдэхүүн	Эр	Эм
<i>Буурсан</i>	75.6%	76.2%	<i>Тийм</i>	15.2%	16.7%
<i>Өссөн</i>	7.6%	9.2%	<i>Үгүй/Мэдэхгүй</i>	78.3%	74.2%
<i>Өөрчлөгдөөгүй</i>	16.8%	14.6%	<i>Шаардлагагүй</i>	6.5%	9.1%
	100%	100%		100%	100%
Цэвэр ашиг			Ажилчдын үр чадвар		
<i>Ашигтай</i>	31.5%	33.2%	Маш сайн	14.4%	15.1%
<i>Алдагдалтай</i>	47.6%	46.2%	Сайн	56.5%	50.9%
<i>Баланс барьсан</i>	20.9%	20.6%	Боломжийн	23.9%	26.6%
			Муу	3.5%	5.0%
Цомхотгол			Мэдэхгүй		
<i>Хийсэн</i>	24.9%	22.4%			
<i>Орон тоо нэмэгдсэн</i>	1.4%	1.7%	Дампуурах эрсдэл		
<i>Үгүй</i>	73.7%	75.9%	1-6 сар	68.8%	62.7%
			7-12 сар	5.9%	6.7%
Судалгаа хөгжүүлэлт			12+ сар		
<i>Тийм</i>	14.5%	14.3%	Нөлөөлөхгүй	11.2%	11.0%
<i>Үгүй/Мэдэхгүй</i>	78.4%	75.6%	Мэдэхгүй	8.8%	11.1%
<i>Шаардлагагүй</i>	7.0%	10.0%			

ҮР ДҮН: Үгүй. Цар тахлын үед эмэгтэй захиралтай жижиг, дунд бизнес эрхлэгчид эрэгтэй захиралтай ижил түвшний компаниудаасаа илүү сайн ажиллаж байна. Эмэгтэй захиралтай компаниудын борлуулалтын орлого 1.6 нэгж хувиар, цэвэр ашиг 1.7 нэгж хувиар эрэгтэй захиралтай компаниудаас илүү байхын зэрэгцээ 2.5 нэгж хувиар бага цомхотгол хийсэн. Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэхэд эмэгтэй захиралтай компани эрэгтэй захиралтай компаниудаас 1.5 нэгж хувиар илүү шургуу ажилласан нь анхаарал татна.

Түүнчлэн эмэгтэй захиралтай аж ахуйн нэгжүүд дахин хатуу хөл хорио тогтоовол 6 сарын дотор үйл ажиллагаагаа зогсоож дампуурах эрсдэл нь эрэгтэй захиралтай компаниудаас бүтэн 6.1 нэгж хувиар бага байна. Өөрөөр хэлбэл хямралын үед ЖДҮ салбарын дундаж Монгол эмэгтэй захирал дундаж эрэгтэй захирлаас илүү үр дүнтэй удирдлага, зохион байгуулалт хийж оновчтой шийдвэрүүд гаргаж байна гэсэн дүгнэлт хийв.

Таамаглал №2: Байгууллагын туршлага буюу оршин тогтносон хугацаа хямралыг давахад эерэгээр нөлөөлж байна уу?

Тайлбар: Азийн хөгжлийн банкнаас Зүүн өмнөд Азийн орнуудын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн дунд хийсэн 2020 оны судалгаагаар Индонез, Малайз зэрэг улсуудад эмэгтэй захиралтай жижиг, дунд бизнесийн компаниуд эрэгтэй захиралтай компаниудтай харьцуулахад цар тахлын сөрөг нөлөөгөөр санхүүгийн хүндрэлд орох эрсдэл нь 10 нэгж хувиар өндөр байгааг харуулсан. Иймд манай улсын ЖДБЭ-дэд энэ төрлийн хүндрэл үүсч буй эсэхийг нягтлав. Хүснэгт 8-ийг үзнэ үү.

Хүснэгт 8. Цар тахлын үед эмэгтэй, эрэгтэй захирлуудад ажлын ялгаа гарсан уу?

Борлуулалтын орлого	1-3	4-6	7-9	10+	Шинэ бүтээгдэхүүн	1-3	4-6	7-9	10+
Буурсан	72%	75%	78%	78%	Тийм	14%	19%	17%	14%
Өссөн	11%	9%	9%	6%	Үгүй/Мэдэхгүй	75%	74%	76%	79%
Өөрчлөгдөөгүй	17%	16%	13%	16%	Шаардлагагүй	11%	8%	6%	7%
Цэвэр ашиг					Ажилчдын үр чадвар				
Ашигтай	11%	9%	9%	6%	Маш сайн	13%	14%	15%	17%
Алдагдалтай	72%	75%	78%	78%	Сайн	54%	58%	55%	50%
Баланс барьсан	17%	16%	13%	16%	Боломжийн	25%	24%	23%	28%
					Муу	4%	3%	5%	4%
Цомхотгол					Мэдэхгүй				
Хийсэн	25%	23%	20%	26%					
Орон тоо нэмэгдсэн					Дампуурах эрсдэл				
Үгүй	3%	2%	0%	1%	1-6 сар	64%	69%	70%	62%
					7-12 сар	7%	7%	5%	6%
Судалгаа хөгжүүлэлт					12+ сар				
Тийм	21%	19%	18%	22%	Нөлөөлөхгүй	12%	9%	11%	12%
Үгүй/Мэдэхгүй	72%	72%	72%	70%	Мэдэхгүй	11%	8%	7%	12%
Шаардлагагүй	7%	9%	10%	8%					

ҮР ДҮН: **Зарим талаар тийм.** Цар тахлын үед 10 буюу түүнээс олон жил ажилласан, туршлагатай компаниудын орлого шинэ тутам компаниудаас 6 нэгж хувиар илүү буурсан. Мөн цэвэр ашиг 5 нэгж хувиар илүү багассан. Харин туршлагатай компаниуд судалгаа хөгжүүлэлтэд илүү анхаарч ажилчдын үр чадвараа харьцангуй сайнаар үнэлж байна. Туршлагатай компаниудын хувьд 6 сарын дотор дампуурах магадлал хамгийн бага байна.

Таамаглал №3: Захирлын боловсролын түвшин хямралыг давахад эерэгээр нөлөөлж чадаж байна уу?

Тайлбар: Захирлын боловсролын түвшин нэмэгдэх тусам тухайн компанийн ашигт ажиллагаа нэмэгдэх боломжтой гэсэн түгээмэл ойлголт бизнес эрхлэгчид, судлаачдын дунд байдаг. Энэ ойлголт цар тахлын энэ хүнд үед батлагдах эсэхийг шалгах нь бидний зорилт байв. Үр дүнг Хүснэгт 9-өөс харна уу.

Хүснэгт 9. Боловсролын түвшин хямралын менежментэд эерэгээр нөлөөлөх үү?

Борлуулалтын орлого	Дээд	Дунд	Бага
Буурсан	76.8%	73.9%	66.7%
Өссөн	8.1%	9.9%	0.0%
Өөрчлөгдөөгүй	15.1%	16.2%	33.3%
	100.0%	100.0%	100.0%
Цэвэр ашиг			
	Дээд	Дунд	Бага
Ашигтай	30.4%	37.0%	43.3%
Алдагдалтай	47.0%	47.6%	36.7%
Баланс барьсан	22.7%	15.4%	20.0%
Оршин тогтнох чадвар	Дээд	Дунд	Бага

1-6 сар	67.1%	63.8%	46.7%
7-12 сар	6.3%	5.6%	13.3%
12+ сар	6.3%	8.4%	13.3%
Нөлөөлөхгүй	11.0%	11.4%	10.0%
Мэдэхгүй	9.4%	10.9%	16.7%

ҮР ДҮН: Эсрэгээрээ. Цар тахлын үед дээд боловсрол эзэмшсэн захиралтай компаниудын борлуулалтын орлого хамгийн өндөр буюу 76.8 хувиар буурсан бол бага боловсролтой захирлуудын орлого 10 нэгж хувиар буюу 66.7 хувиар багассан. Мөн бага боловсролтой захирлуудын цэвэр ашиг дээд боловсролтой захирлаас 13 хувиар, дунд боловсролтой захирлуудаас 6 хувиар илүү байв.

Хөл хорио цаашид үргэлжилбэл 6 сарын дотор дээд боловсролтой захирлуудын дампуурах магадлал 67.1%, дунд боловсролтой бол 63.8% байсан бол бага боловсролтой захирлуудынх ердөө 46.7% байна. Манай улсын жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт “боловсролын дилемма үүссэн үү?”.

Таамаглал №4: Цар тахлын үед эдийн засгийг сэргээх зарим зорилтот хөтөлбөрүүд онилсон салбартаа үр дүн өгч байна уу?

Тайлбар: Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, эдийн засгаа сэргээх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г 2021 оны 42 дугаар тогтоолоор 56 арга хэмжээтэйгээр батлан хэрэгжүүлж байгаа билээ. Цогц төлөвлөгөөнд иргэдийн эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг бүрдүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих, ажлын байрыг хадгалах, иргэдийг орон сууцжуулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, малчдын орлого, амьжиргааг дэмжих болон уул уурхайн бүс экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, иргэн, аж ахуйн нэгжид олгох зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг тусгасан байдаг. Эдгээр арга хэмжээнүүдээс тухайлан “ипотекийн 6%-ийн хүүтэй зээл” болон “ХАА салбарт хаврын тариалалт, ноос, арьс шир худалдан авалтыг дэмжих, малчдын хөнгөлөлттэй зээл”-ийн үр дүнг зорилтот салбарууд болох барилга, боловсруулах болон ХАА-н компаниуд дээр шалгав Үр дүнг Хүснэгт 10-ыг харна уу.

Хүснэгт 10. Төсвийн зорилтот хөтөлбөрүүд үр дүн өгч байна уу?

Ипотекийн 6%-ийн зээл	Барилга	Боловсруулах	Хувь	Хувь
Маш сайн	1	1	0.8%	0.6%
Сайн	1	2	0.8%	1.2%
Тааруухан	2	3	1.6%	1.8%
Нөлөөгүй/Мэдэхгүй	119	163	96.0%	96.4%
Сөрөг нөлөөлсөн	1	0	0.8%	0.0%
	124	169	100%	100%
ХАА салбарт хаврын тариалалт, ноос, арьс шир, малчдын хөнгөлөлттэй зээл				
	ХАА		Хувь	
Маш сайн	0		0.0%	
Сайн	9		12.3%	
Тааруухан	1		1.4%	
Нөлөөгүй/Мэдэхгүй	63		86.3%	
Сөрөг нөлөөлсөн	0		0.0%	

	73		100%	
--	----	--	------	--

ҮР ДҮН: Үгүй. Засгийн газраас “цар тахлын үед эдийн засгаа сэргээх” бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд байгаа онохгүй байна. Жишээ нь ипотекийн 6%-ийн зээл барилгын болон боловсруулах үйлдвэрлэлийн салбар дахь 293 компанийн ердөө 10 компанид тодорхой хэмжээгээр эерэг нөлөө үзүүлсэн (3.2%, 3.6%).

Мөн хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй зээлийн төрөл бүрийн дэд хөтөлбөрүүд, төсвийн дэмжлэгийн талаар ХАА-н компаниудын 86.3 хувь нь эдгээр хөтөлбөр “нөлөөгүй” эсхүл “мэдэхгүй” гэж хариулжээ.

Таамаглал №5: Компанийн хэмжээ (борлуулалтаар) шинэ дэвшилтэд бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд эерэгээр нөлөөлж чадах уу?

Хүснэгт 11. Борлуулалт болон шинэ дэвшилтэд бүтээгдэхүүний хоорондын уялдаа

	Бичил I	Бичил II	Жижиг	Дунд	Бичил I	Бичил II	Жижиг	Дунд
Тийм	104	93	34	15	12.3%	19.0%	23.1%	24.2%
Үгүй	661	343	104	45	78.0%	70.1%	70.7%	72.6%
Шаардлагагүй	66	46	6	2	7.8%	9.4%	4.1%	3.2%
Мэдэхгүй	16	7	3	0	1.9%	1.4%	2.0%	0.0%
Нийт	847	489	147	62	100%	100%	100%	100%

ҮР ДҮН: Тийм. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд борлуулалт нэмэгдэж хэмжээ томрох тусам шинэ дэвшилтэд бүтээгдэхүүн нэвтрүүлэх чадамж нэмэгдэж, үр дүн сайжирч байна. Дунд түвшний бизнес эрхлэгчдийн хувьд бичил бизнес эрхлэгчдээс шинэ дэвшилтэд бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлэх гүйцэтгэл 12 нэгж хувиар өндөр байна. Нөгөө талаар бичил бизнес эрхлэгчдийн хувьд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх шаардлагагүй гэж хариулсан тоо жижиг болон дунд бизнес эрхлэгчдээс 2-3 дахин өндөр буйг судалгаа харууллаа.

Таамаглал №6: Компанийн “хэмжээ” (борлуулалтаар) бүтээгдэхүүн борлуулахад үүсдэг үндсэн хүндрэлүүдтэй холбоотой юу?

Хүснэгт 12. Борлуулалт хэмжээ болон үүсч буй хүндрэлүүдийн хоорондын уялдаа

Бүтээгдэхүүн борлуулахад үүсч буй үндсэн хүндрэлүүд	Бичил I	Бичил II	Жижиг	Дунд
Коронавирусын хөл хорио	59.5%	59.8%	59.6%	59.6%
Орон нутгийн худалдан авах чадвар сул	17.6%	16.3%	20.7%	16.9%
Дотоодын тээврийн сүлжээ хөгжөөгүй	7.0%	6.3%	11.3%	4.5%
Стандартын агуулах, зорь хангалтгүй	8.7%	11.4%	2.0%	4.5%
Худалдан авагч нь монополь шинжтэй	3.3%	2.0%	3.4%	9.0%
Нийлүүлэлтийн шаталсан бүтэц мүү	1.8%	1.7%	1.5%	1.1%
Хэрэглэгчээс хол байрласан	2.1%	2.5%	1.5%	4.5%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%

ҮР ДҮН: Үгүй. Коронавирусын хөл хорионы улмаас бичил, жижиг, дунд аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүнээ борлуулахад бараг ижил хүндрэлүүд тохиолдож байна. Дунд хэмжээний аж ахуйн нэгжүүдэд худалдан авагч тал нь монополь шинжтэй болон хэрэглэгчээс хол байрласан нь тодорхой хэмжээгээр дарамт болж байна.

Харин бичил бизнесүүдэд стандартын агуулах, зоорь хангалтгүй байдаг ажээ. Мөн жижиг бизнест орон нутгийн худалдан авах чадвар сөргөөр нөлөөлж байна.

Таамаглал №7: Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд макро эдийн засгийн орчин ялгаатай нөлөөлж байна үү?

Хүснэгт 13. Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн ЖДБЭ-дэд үзүүлэх ялгаатай нөлөөллүүд

Эдийн засгийн байдал	Бичил I	Бичил II	Жижиг	Дунд
Маш сайн	0.1%	1.0%	1.4%	0.0%
Сайн	1.9%	1.4%	2.7%	0.0%
Нөлөөлдөггүй	5.8%	6.3%	6.1%	11.3%
Муу	60.0%	54.0%	69.4%	62.9%
Маш муу	29.3%	35.6%	17.0%	25.8%
Мэдэхгүй	3.0%	1.6%	3.4%	0.0%
Инфляци				
Маш сайн	0.2%	0.4%	0.7%	0.0%
Сайн	0.6%	1.4%	0.7%	0.0%
Нөлөөлдөггүй	4.5%	3.1%	5.4%	6.5%
Муу	47.1%	40.9%	49.0%	59.7%
Маш муу	46.3%	53.4%	42.9%	33.9%
Мэдэхгүй	1.3%	0.8%	1.4%	0.0%
Төгрөгийн ханш				
Маш сайн	0.8%	0.6%	0.0%	1.6%
Сайн	0.6%	1.2%	1.4%	0.0%
Нөлөөлдөггүй	14.0%	12.3%	14.3%	14.5%
Муу	42.6%	40.7%	51.0%	48.4%
Маш муу	38.4%	40.1%	30.6%	35.5%
Мэдэхгүй	3.5%	5.1%	2.7%	0.0%
Гадаадын хөрөнгө оруулалт				
Маш сайн	0.4%	0.8%	0.0%	3.2%
Сайн	4.7%	7.0%	5.4%	6.5%
Нөлөөлдөггүй	34.6%	29.2%	44.2%	46.8%
Муу	11.7%	12.7%	12.9%	17.7%
Маш муу	5.4%	5.1%	4.8%	3.2%
Мэдэхгүй	43.2%	45.2%	32.7%	22.6%

ҮР ДҮН: **Зарим талаар тийм.** Эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал бүх ЖДБЭ-дэд муугаар нөлөөлж буй боловч дунд бизнесийн хувьд муу нөлөөлөл нь бусдаас арай бага байна. Бүтээгдэхүүний үнийн өсөлт бизнес эрхлэгчдэд сөргөөр нөлөөлж буй боловч Бичил II бизнес эрхлэгчдэд хамгийн хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байна.

Төгрөгийн ханшийн уналт дунд хэмжээний компаниудыг хамгийн сөрөг буюу 84%-д нь “муу, маш муу”-гаар нөлөөлж байна. Гадаадын хөрөнгө оруулалт дунд түвшний бизнесүүдийн 10 орчим хувьд нь “маш сайн, сайн”-аар нөлөөлж буй бол бичил бизнес эрхлэгчдийн 45% нь мэдэхгүй гэж хариулжээ.

Таамаглал №8: Экспортод бүтээгдэхүүн гаргадаг жижиг, дунд бизнес эрхлэгчдэд төгрөгийн ханшийн уналт сайнаар нөлөөлж чадаж байна уу?

Тайлбар: Эдийн засгийн онол, практик талаасаа төгрөгийн ханшийн уналт нь экспортод бүтээгдэхүүнээ гаргадаг Монгол Улсын жижиг, дунд бизнесийн байгууллагуудад эерэгээр нөлөөлөх боломжтой юм. Гэвч дийлэнх жижиг, дунд бизнес эрхлэгчид нь бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эд, орцоо импортоор авдаг гэж хариулсныг санах нь зүйтэй. Дэлгэрүүлэн Хүснэгт 14-ийг харна уу.

Хүснэгт 14. Төгрөгийн ханшийн уналт ба экспортлогч ЖДБ эрхлэгчид

Төгрөгийн ханшийн уналт	Экспортлогч ЖДБЭ	Дотоодын ЖДБЭ	Экспортлогч ЖДБЭ	Дотоодын ЖДБЭ
Маш сайн	6	4	10.3%	0.3%
Сайн	5	8	8.6%	0.5%
Нөлөөлдөггүй	9	201	15.5%	13.5%
Муу	20	645	34.5%	43.4%
Маш муу	16	572	27.6%	38.5%
Мэдэхгүй	2	57	3.4%	3.8%
Нийт	58	1487	100%	100%

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн орцод эзлэх дотоодын түүхий эд, нөөцийн хувь

1-25%	15	25.9%
26-50%	12	20.7%
51-75%	4	6.9%
76-100%	25	43.1%
Мэдэхгүй	2	3.4%
	58	100.0%

ҮР ДҮН: **Үгүй.** Судалгаанд оролцсон 58 экспортлогч бизнесийн хувьд ердөө 20 хүрэхгүй хувь нь төгрөгийн ханшийн уналт “маш сайн, сайн” нөлөөтэй гэж хариулсан нь хангалтгүй юм. Учир нь олон экспортлогч компаниудын бүтээгдэхүүн үйлдвэрлэх орцод импортын түүхий эд голлох байр суурийг эзэлж байна (46.6%).

Таамаглал №9: Замын-Үүд, Алтанбулаг боомтууд дээрх хүндрэл экспортлогчдод сөрөг нөлөө үзүүлж байна уу?

Хүснэгт 15. Томоохон хилийн боомтуудын нөхцөл байдал ба экспортлогч ЖДБ эрхлэгчид

Зам-Үүд, Алтанбулаг боомтын эффект	Экспортлогч	Импортлогч	Экспорт хувь	Импорт хувь
Маш сайн	1	1	1.7%	0.1%
Сайн	3	7	5.2%	0.6%
Нөлөөгүй	14	205	24.1%	18.7%
Муу	14	468	24.1%	42.6%
Маш муу	24	388	41.4%	35.3%
Мэдэхгүй	2	29	3.4%	2.6%
Нийт	58	1098	100%	100%

ҮР ДҮН: Тийм. Судалгаанд оролцсон 58 экспортлогч бизнесийн байгууллагын 65.5 хувь нь Замын-Үүд, Алтанбулаг боомтууд дахь хүндрэл үйл ажиллагаанд нь “Муу, маш муу”-гаар нөлөөлж байна гэж хариулсан. Энэ нь импортлогч компаниудтай харьцуулахад хүндрэлийн түвшин ердөө 12.4 нэгж хувиар л бага байна (77.9%). Иймд хилийн боомтууд дээр үүссэн асуудал нь 2 талтай буюу импортлогч, экспортлогч аж ахуйн нэгж хоюуланд нь сөргөөр нөлөөлж байна.

Таамаглал №10: Цар тахал, хатуу хөл хорио бизнесийн салбаруудад ижилхэн сөрөг нөлөө үзүүлсэн үү?

Хүснэгт 16. Томоохон хилийн боомтуудын нөхцөл байдал ба экспортлогч ЖДБ эрхлэгчид


Салбарууд	Борлуулалтын орлого			Ашигтай ажилласан эсэх		
	Өссөн	Буурсан	Хэвээр	Ашигтай	Алдагдалтай	Баланс
Хөдөө аж ахуй	5.5%	78.1%	16.4%	21.9%	53.4%	24.7%
Боловсруулах үйлдвэрлэл	8.3%	78.7%	13.0%	29.6%	52.7%	17.8%
Барилга	5.6%	83.1%	11.3%	29.0%	53.2%	17.7%
Бөөний/жижиглэн худалдаа	8.2%	73.2%	18.6%	36.5%	39.9%	23.6%
Тээвэр, агуулах	5.3%	86.0%	8.8%	12.3%	66.7%	21.1%
Байр, сууцны түрээс, гуанз	8.2%	75.4%	16.4%	38.1%	46.3%	15.7%
Мэдээлэл, холбоо	15.6%	62.5%	21.9%	37.5%	37.5%	25.0%
Боловсрол, шинжлэх ухаан	6.1%	75.8%	18.2%	21.2%	54.5%	24.2%
Аялал жуулчлал	5.6%	94.4%	0.0%	13.9%	72.2%	13.9%
Эрүүл мэнд	14.6%	69.7%	15.7%	32.6%	43.8%	23.6%
Урлаг, үзвэр	6.3%	87.5%	6.3%	25.0%	68.8%	6.3%
Уул уурхай, үл хөдлөх	10.3%	77.0%	12.6%	32.2%	55.2%	12.6%

ҮР ДҮН: Зарим талаар тийм. Бүх салбаруудад борлуулалтын орлого 60%-иас дээш буурсан боловч мэдээлэл, холбоо болон эрүүл мэндийн салбарт тодорхой өсөлтүүд ажиглагдав. Тээвэр агуулах, аялал жуулчлал, урлаг үзвэрийн салбаруудад уналт хамгийн хүчтэй мэдрэгдсэн бол худалдаа, түрээс, мэдээлэл холбоо, эрүүл мэндийн салбаруудын 3 компани тутмын 1 нь өнгөрсөн онд ашигтай ажиллаж чадсан байна.

1.7. ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ЭРГЭХ ХОЛБОО

Монгол Улсын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварын талаарх энэхүү судалгааг тодорхой хугацааны давтамжтайгаар тогтмол авч байх нь судалгааны динамик байдлыг хангах бөгөөд илүү чанартай, илүү бодитой үр дүн гаргахад чухал ач холбогдолтой байх болно. Судалгаанд оролцсон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд түүвэр судалгааны чанар, ач холбогдлын түвшнээс хамааруулан энэ төрлийн судалгаанд дахин оролцох хүсэлт ихээр гаргах нь цаашдын судалгааны ажлуудад чухал түлхэц болно. Иймд бид бүх судалгаанд оролцсон талуудаас энэ төрлийн судалгааг ирэх жил дахин авбал оролцох сонирхолтой эсэхийг нь нягтлан судлахыг зорьсон юм. Үр дүнг Зураг 53-аас харна уу.

Зураг 53. Ирэх жил ийм төрлийн судалгаанд дахин оролцох эсэх




Үр дүн: Судалгаанд оролцсон нийт аж ахуйн нэгжүүдийн 91.3% нь буюу 10 компани тутмын 9 нь энэхүү судалгааг ирэх жилүүдэд авбал дахин оролцох хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд ердөө 3.9% нь оролцох хүсэлгүй байгаагаа илэрхийлсэн. Өөрөөр хэлбэл судалгааны approval rate 90%-иас дээш, denial rate 4%-иас доош гарав.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Манай улс 1990-ээд оны эхэнд эдийн засгийн төвлөрсөн төлөвлөгөөт системээс чөлөөт зах зээлийн эдийн засагруу шилжилт хийсэн хөгжиж буй эдийн засагтай орон. Сүүлийн 20 жилд манай улсын уул уурхайн салбарт их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж түс салбарын өсөлт эдийн засгийн өсөлтөд ихээхэн дэмжлэг болсон. Үүний үр дүнд улсын эдийн засагт голлох нөлөө үзүүлэх салбар нь хөдөө аж ахуйгаас уул уурхайн салбар болсон билээ. Сүүлийн 10 жилд уул уурхайн салбар ДНБ-ий 20 гаруй хувийг дангаар бүрдүүлж байна. Дараах графикаар өсөлтийн дундажийг харууллаа.

График 1. ДНБ-ний өсөлт, салбараар




Эх сурвалж: ҮСХ

2.1. Макро эдийн засгийн нөхцөл байдал

2021 оны эхний хагаст Монгол Улсын эдийн засаг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.3%-иар өсчээ. Уг өсөлтийн дийлэнх буюу 5.7 нэгж хувийг уул уурхайн салбар болон бүтээгдэхүүний цэвэр татвар бүрдүүлжээ. Мөн хугацаанд худалдааны салбар бага зэрэг эерэг өсөлттэй байсан бол хөдөө аж ахуй (ХАА) болон барилгын салбарууд уналттай байлаа. Бусад салбаруудын хувьд өсөлт төдийлөн сайнгүй байна. Уул уурхайн салбарын өсөлт голчлон нэгдүгээр улиралд буй болсон сэргэлттэй холбоотой бөгөөд хоёрдугаар улиралд бараг өсөлт ажиглагдаагүй юм (График 2).

График 2. Эдийн засгийн жилийн өсөлт



Эх сурвалж: ҮСХ

Ковид-19 цар тахал ийнхүү эдийн засгийн бүх секторүүдэд сөргөөр нөлөөлсөөр байна. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хамгийн түгээмэл эрхэлдэг худалдаа, үйлчилгээний салбарууд уналттай байлаа.

Уул уурхайн салбар хэдийгээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн, мөн түүхий эдийн үнэ 30-50 орчим хувиар өссөн хэдий ч цар тахлын улмаас үүдэлтэй хилийн хорио цээрийн дэгдэм, арга хэмжээ нь нүүрсний экспортын биет хэмжээ 2019 онтой харьцуулахад 2021 онд 2 дахин бага байхаар байна. Эдийн засгийн идэвхижилтэй зэрэгцээд ирэхээр импорт өссөн боловч ч гааль дээр үүссэн ариутгалтай холбоотой хязгаарлалт сөргөөр нөлөөлсөн хэвээр байна.

Цар тахлын нөлөөгөөр экспортын орлого буурч, үрсгал тэнцэл алдагдалтай, төлбөрийн тэнцэл алдагдалтай байгаа боловч төгрөгийн нэрлэсэн ханш бараг тогтмол байна. Үүний үр дүнд гадаад валютын нөөц буурчээ. Өнгөрсөн оны 12 сараас хойш төгрөгийн ханш тогтмол байсан нь ЖДҮ-ийн 45 хувийг бүрдүүлж буй худалдааны салбарынханд цар тахлын сөрөг нөлөөг намжаасан байна. ЖДҮ-ийн 80 гаруй хувь нь ханш суларвал бизнест нь сөргөөр нөлөөлнө гэж хариулсан байсан. Гэхдээ бодит ханш ихээр чангарсан нь дотоодын үйлдвэрлэгчид сөргөөр нөлөөлөх, хилийн хязгаарлалт буурвал тэдний өрсөлдөх чадвар буурах эрсдэлтэй харагдаж байна. Энэ бүлэгт бидний ЖДҮ түүврийн 11 хувь нь орж байна.

Гэхдээ ирэх онуудад экспортын орлого дорвитой өсөхгүй, импорт өсвөл төгрөгийн ханшинд ирэх дарамт өсөх юм. Өөрөө хэлбэл, ЖДҮ-ийн бизнест ханшийн зүгээс дарамт ирнэ.

Ажил эрхлэлт ба өрхийн орлого

2020 оны 1-р сарын сүүлээс эхлэн Ковид-19 цар тахлын гэнэтийн шок Монгол улсын нийгэм, эдийн засагт сөргөөр нөлөөлж эхлэв. Тухайлбал, 2020 онд Монгол улсын эдийн засаг 4.6 хувь болж агшсан. Цар тахлыг хүмийх зорилготой удаа дараагийн хөл хорио, гадаад эрэлт, хөрөнгө оруулалт буурсан зэрэг нь дотоодын эдийн засагт эрэлт, нийлүүлэлтийн шок үүсгэж аж ахуйн нэгжүүдэд ихээхэн хүндрэл бий болгож улмаар орлого, ажил эрхлэлтэд ихээхэн сөрөг нөлөө үзүүлэв. Тухайлбал, ажиллагсадын тоо 2020 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 63.9 мянгаар, буюу 5 хувиар буурсан байна. Түүнчлэн, 2020 оны 1 улирлын байдлаар ажилгүй хүний тоо 83 мянга бөгөөд ажилгүйдлийн түвшин 6.6% байсан бол 2021 оны 2 дугаар улирлын байдлаар ажилгүй хүний тоо өссөөр 101 мянга, ажилгүйдлийн түвшин 8.4% болжээ. Түүнчлэн өрхийн нийт орлого ба зарлагын түвшин 2017-19 онуудад жилд даруй 15 орчим хувиар өсч ирсэн бол 2020 онд бараг өсөлтгүй гарсан байна (График 4). 2021 оны 2 дугаар улиралд өрхийн орлого ба зарлага бага зэрэг өсөлт үзүүлсэн нь хөл хорионы сөрөг нөлөөнөөс хамгаалах зорилгоор иргэдэд олгосон шилжүүлэгтэй холбоотой.

График 3. Ажилгүйчүүд ба ажилгүйдлийн түвшин





График 4. Өрхийн орлого ба зарлага (жилийн өсөлт)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2020 оны сүүлийн хагас жилийн хугацаанд зохион байгуулсан 3 удаагийн дараалсан санал асуулгад оролцсон иргэдээс Ковид-19 цар тахлын нөлөөгөөр цалин хөлстэй ажил, хөдөлмөр эрхлээгүй 10 хүний ердөө 6 нь “хөл хорионы дэглэм цуцлагдахад буцаж ажилдаа орно” гэжээ. Харин 4 дэх шатанд (2021/4/19-30) хөл хорио цуцлагдаж хөдөлмөр эрхлэлтийн байдал сэргэсэн ч хувиараа бизнес эрхэлдэг өрхүүдийн 82 хувь нь бизнес эрхлэх боломжгүй мөн тэдний 88 хувь нь цар тахлын өмнөх үеийнхээс орлого нь буурсан гэжээ (Дэлхийн банк, 2021). Ийнхүү цар тахал өрхүүдийн болон хувиараа бизнес эрхлэгч нарт нөлөөлж, цар тахлын дараах сэргэлт удаашралтай байна. Эндээс харахад эдийн засгийн эрэлтийн гол тодорхойлогч болсон өрхийн худалдан авах чадвар, түүнийг дэмжигч ажил эрхлэлтийн байдал тааруу нөхцөлд байна. Цар тахлын цаашдын нөхцөл байдал, уул уурхайн экспортын сэргэлт зэрэг нь эдийн засгийн сэргэлтэнд чухал нөлөө үзүүлнэ.

Банкны салбарын зээл

2020 онд цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн идэвхжил суларч улмаар банкны салбарын зээлийн үлдэгдэл 17 их наяд болон буураад байсан. Банкны салбараас зээл гаралт багасах нь эдийн засаг дахь мөнгөний эргэлт, бодит эрэлтийг бууруулж эдийн засгийн өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлдэг. Уг гинжин хэлхээг тасалж, эрэлтийг дэмжих зорилгоор 2021 оны 2 дугаар сард “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наяд төгрөгийн цогц төлөвлөгөө”-ийг Засгийн газраас батлан, Монголбанк болон арилжааны банкуудтай хамтран хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Уг төлөвлөгөө хэрэгжиж эхэлснээр банкуудын Жижиг, дунд үйлдвэрлэл болон уул уурхайн бүс экспортод чиглэсэн шинэ зээл олголт болон дахин санхүүжүүлэлт идэвхжин 2021 оны хоёрдугаар улирлын байдлаар зээлийн үлдэгдлийн хэмжээ өмнөх оны эцсээс даруй 2 их наяд төгрөг буюу 12%-иар өссөн байна.

График 5. Банкны салбарын зээлийн үлдэгдэл (салбараар)




График 6. Банкны салбарын чанаргүй зээлийн хувь хэмжээ



Эх сурвалж: Монголбанк

Хэдийгээр жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих чиглэлд эерэг үр дүн харагдаж байгаа боловч банкны системийн нийт чанаргүй зээлийн хэмжээний хувьд анхаарах асуудлууд байсаар байгаа. Тухайлбал банкны секторын нийт чанаргүй зээлийн хувь хэмжээ 2021 оны 7 дугаар сарын байдлаар 9.9% байна.

Уул уурхай, ХАА болон Барилгын салбарын 5 зээл тутмын 1-нь чанаргүйтэж байгаа бол боловсруулах салбарын 4 зээл тутмын 1-нь чанаргүйтэж байна. Энэ нь 2020 оны 4 дүгээр улирал буюу Засгийн газрын цогц төлөвлөгөө хэрэгжиж эхлэхээс өмнөх 11.3%-иас бага боловч чанаргүй зээлийн нийт хэмжээ мөнгөн утгаараа 2 их наяд орчимд байсаар дорвитой буурахгүй байгааг илэрхийлэхгүй байна. Зээлийн чанарын ангиллыг бууруулах хугацаа хэтэрсэн хоногийг 90 хоног болгосон байгааг (ковидын нөхцөл байдалтай холбоотой) 2021 оны наймдугаар сараас 75 хоног, 2021 оны аравдугаар сараас 60 хоног, 2021 оны арванхоёрдугаар сараас 45 хоног, 2022 оны хоёрдугаар сараас 30 хоног, 2022 оны дөрөвдүгээр сараас 15 хоног болгож хэвийн горимд аажмаар шилжүүлэхээр зохицуулжээ. Түүвэр судалгаанд оролцсон байгууллагуудын 19 хувь нь банкны зээлтэй байгаа бөгөөд эдгээр байгууллагуудын хувьд дээрх өөрчлөлт нь сөргөөр нөлөөлж магадгүй байна.

Монгол банкнаас цар тахлын эсрэг бодлогын хүрээнд зээлийн нөхцөл өөрчлөх, хөнгөлөлттэй зээл авах зэргээр тодорхой хэмжээнд зээлийн чанараа хэвийн төлөвт хадгалж чадаж байсан бол энэ нь хөнгөлөлт ойрын хугацаанд аажмаар алга болох юм. 2022 он гарсаар хөнгөлөлттэй зээл авсан ААН-үүдийн зээлийн эргэн төлөлт эхэлнэ. Энэ нь бизнесийн зээлийн чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Түүнчлэн иргэдийн зээл он гараад муудах дүр зурагтай байна.

Инфляци ба хүүний түвшин

2021 оны 8 дугаар сарын байдлаар улсын инфляци 8.9%-д хүрсэн. Инфляци ийнхүү огцом нэмэгдэхэд махны үнэ, хатуу болон шингэн түлшний үнэ нэмэгдсэн, гадаад худалдааны тээврийн зардал нэмэгдсэнтэй голчлон холбоотой байна. Цар тахлын улмаас далайн тээврийн үнэ 5 дахин өссөн, мөн хилийн хязгаарлалтаас болоод нийлүүлэлтийн

сүлжээний доголдол үүсч байгаа зэрэг нь дэлхий даяр үйлдвэрлэгчдийн хувьд томоохон хүндрэл болж улмаар бараа бүтээгдхүүний үнэд сөргөөр нөлөөллөө.

Монголбанкны зүгээс эдгээрийн нийлүүлэлтийн хүчин зүйлс хэмээн тайлбарлаж, мөнгөний бодлогоо зөөлөн хадгалах шийдвэрийг 2021 оны 9 дүгээр сарын ээлжит Мөнгөний бодлогын хорооны хурлаараа гаргасан.

График 7. Жилийн инфляци





График 8. Хүүний түвшин (тухайн сард шинээр)



Эх сурвалж: Монголбанк

Монголбанкны хувьд 2020 оны 3 дугаар сараас хойш Ковид-19 цар тахлын улмаас инфляци болон эдийн засгийн өсөлт удааширсантай бодлогын хүүгээ шат дараалан буулгасаар 2020 оны 11 дүгээр сард 6%-д хүргэн одоог хүртэл уг түвшинд хадгалсаар байна. Бодлогын хүү буурахын зэрэгцээ Ковид-19 цар тахлын хуультай холбоотойгоор харилцах, хугацаагүй хадгаламжийн дансанд хүү тооцохгүй болсон зэргээс шалтгаалан банкуудын шинэ эх үүсвэр (хадгаламж) болон шинэ зээлийн хүү эрчимтэй буурсаар байна. Үүний зэрэгцээ төрийн зүгээс хөнгөлөлттэй зээл олгож байгаа нь хүүний түвшин буурах нэмэлт хүчин зүйл болж байна.

Дэлхий даяар томоохон эдийн засгуудад хүүний түвшин буурсан нь дотоодын хүү буурах суурь нөхцөл болж өгсөн. Харин сүүлийн саруудад АНУ, Европ зэрэг хөгжингүй орнуудын инфляци эрчимтэй нэмэгдэж байгаа нь хүүний түвшин харьцангуй ойрын хугацаанд эргэн нэмэгдэж магадгүй нөхцөлийг бий болголоо. Түүнчлэн, инфляци өссөн бодит ханш чангарсан зэрэг нь бодлогын хүүг өсгөх нөхцөлийг бүрдүүлж байна. Ирэх оноос Монголбанк бодлогын хүүгээ нэмэх, үүнээс улбаалж зээлийн хүү өсөх магадлал өндөр байгаа нь ЖДҮ-ийн санхүүжилтийн зардлыг өсгөхөөр байна.

Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2020 оны 7 дугаар сараас хойш 2850 төгрөгийн орчимд, Хятадын юаньтай харьцах ханш. 2021 оны эхнээс хойш 440 төгрөгийн орчимд тогтвортой байна (График 9). Гадаад валютын албан нөөц 2021 онд түүхэн дээд түвшинд хүрч, улмаар 2021 оны 7 дугаар сарын байдлаар 4.6 тэрбум ам.доллартай тэнцэж байна (График 10).

График 9. Валютын ханш





График 10. Гадаад валютын албан нөөц (сая ам.д)




Эх сурвалж: Монголбанк

Төсөв

2020 онд Ковид-19-ийн цар тахал болон түүний эсрэг Засгийн газрын хэрэгжүүлсэн бодлоготой холбогдуулан төсвийн алдагдал 4,5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 12.5% хүрч тэлсэн. Аж ахуйн нэгж, иргэдийн татварын орлого болон зарим шимтгэлүүдийг хөнгөлсөн нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд томоохон дэмжлэг болсон бол 2021 оны төсөвт тус хөнгөлөлтүүдийг нэлээдгүй багасгасан юм. 2021 оны эхний хагас жилд экспорт сэргэсэн болон Засгийн газрын татвар, шимтгэлийн хөнгөлөлтүүд багассанаар төсвийн орлого өмнөх онтой харьцуулахад нэлээдгүй өсч, улмаар төсвийн алдагдал эхний 8 сарын байдлаар 1 их наяд төгрөг байна (График 11).

График 11. Төсвийн тэнцэл (их наяд төг, сараар)



Эх сурвалж: ҮСХ

Засгийн газрын хөнгөлөлтүүд багассан ч “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наяд төгрөгийн цогц төлөвлөгөө”-ний хүрээнд олгогдож буй хөнгөлөлттэй зээлүүдэд Засгийн газрын зүгээс татаас өгөх замаар жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж байна. Эдийн засгийг дэмжих 10 их наядын хөтөлбөр 34 хувийн биелэлттэй явж байна. 2022 оны төсөв батлагдсан бөгөөд төсвийн орлого харьцангуй өөдрөг, алдагдал өндөртэй төсөв боллоо. Ирэх онуудад төсвийн орлого тасалдах, улмаар дахин тодотгол хийгдэх магадлал өндөр байна.

2.2. Макро эдийн засгийн цаашидын төлөв


Дэлхийн эдийн засгийн төлөв

2020 оны эхээр дэгдсэн Ковид-19 цар тахал дэлхийн эрүүл мэндийн тогтолцоонд ихээхэн нэмэгдэл ачаалал үүсгэж, халдварыг тогтоон барих зорилготой арга хэмжээний үр дүнд 3.1 хувиар агшаад байсан Дэлхийн эдийн засаг 2021 онд сэргэж 2022 онд тогтворжих төлөвтэй байна.

Дэлхийн эдийн засаг 2021 онд 5.9% хүрч өснө гэж таамаглаж байгаа бөгөөд энэ нь вакцины хамрагдалт, цар тахлыг даван туулахад чиглэсэн бодлогын дэмжлэг мөн түүхийн эдийн үнийн өсөлт зэргээс хамаарахаар байна. Гэсэн ч Ковид-19 вирусын шинэ хувилбар, халдварын шинэ давалгаа нь эдийн засгийн өсөлтөнд сөргөөр нөлөөлөх шинжтэй байна. Өндөр хөгжилтэй орнуудын ДНБ 2021 онд 5.2%-иар өсөх төлөвтэй байгаа бөгөөд энэ нь цар тахлын эсрэг тавьсан хязгаарлалтуудаа зөөлрүүлэх, вакцинжуулалтыг эрчимтэй нэвтрүүлэх, мөн төсөв санхүүгийн бодлогын дэмжлэг зэргээс ихээхэн шалтгаалхаар байна. Түүнчлэн, АНУ-ын эдийн засаг 6%-иар тэлэх төлөвтэй байгаа бөгөөд Сенатаас баталсан 4 их наяд ам.долларын эдийн засгийг сэргээх багцууд нь нийгмийн хамгааллын сүлжээг бэхжүүлэх, өсөлтөд хүчтэй нөлөө үзүүлэх, худалдааны түншүүддээ ихээхэн эерэг нөлөө үзүүлэх төлөвтэй байна гэж дүгнэжээ. Үүний нэгэн адил Японы ДНБ 2.4%-иар өснө гэж тооцоолж байгаа нь гадаад эрэлтийн зэрэгцээ дотоодын эдийн засгийн үйл ажиллагаа сэргэж байгааг харуулж байна. Мөн түүхий эдийн үнийн өсөлт, гадаад эрэлт сайжирснаар эрчимтэй хөгжиж буй болон хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт 6.4%-иар өсөх төлөвтэй байна. БНХАУ-н эдийн засаг 2021 онд 8% болж өснө гэж тооцоолсон бөгөөд хүчтэй өсөлттэй бүс нутгийн сэргэлтийг тэргүүлж, хувийн хэрэглээ болон экспорт нэмэгдсэн нь нөлөөлөх төлөвтэй байна.

Эрэлт нийлүүлэлтийн зөрүүтэй байдал мөн өргөн хэрэглээний барааны үнэ 2020 онд өссөн зэргээс шалтгаалан дэлхийн инфляци 2021 онд бага зэрэг өсч 4.3% байх төлөвтэй байна. Дэлхийн зах зээл дээр газрын тос, металл, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийг дагаад 2021 хөгжингүй орнуудын инфляци 2.8%-иар өсөхөөр байгаа бол эрчим хүч, түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалж 2021 онд хөгжиж буй орнуудын инфляци 5.5%-иар өснө гэж тооцоолж байгаа бөгөөд үүний үр дүнд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өсөх төлөвтэй байна.

График 12. Дэлхийн засгийн төлөв



Эх сурвалж: ОУВС Дэлхийн эдийн засгийн төсөөлөл 2021


Дотоодын эдийн засгийн төлөв

Макро эдийн засгийн ойрын болон дунд хугацааны ерөнхий төлөв байдал, прогноз шинжилгээг энэхүү судалгааны ажлын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Ингэхдээ санхүүгийн програмчлал ашиглан эдийн засгийн салбар тус бүрээр төлөв байдлыг прогнолож улмаар ЖДБ-ын хамгийн олноор үйл ажиллагаа явуулдаг салбаруудыг түлхүү авч үзэж, тэдний бизнес эрхлэх орчинд хэрхэн нөлөөлөхийг тодорхойлов. Санхүүгийн програмчлал нь одоогийн эдийн засгийн шинжилж, ирээдүйн төлвийг тодорхойлж, эдийн засгийн зохистой бодлогыг тодорхойлох Олон Улсын Валютын Сангаас гаргасан аргачилал юм. Энэхүү аргачилалын гол давуу тал нь макро эдийн засгийн гол секторуудын хоорондын хамаарал дээр тулгуурлаж илүү бодитой шинжилгээг хийх юм.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг АХБ, ОУВС 9, 10 сард шинэчилсэн байна. Сангийн яам 2022 оны МУ-н төсвийн төсөлд 4.1 хувь гэж тооцоолсон бол Монголбанк 5.1, Азийн хөгжлийн банк 4.6 хувь 10 сарын төсөөлөлдөө үзжээ. Харин 2022 оны өсөлтийг Сангийн яам 5 хувь, Монголбанк 5.8 хувь, АХБ 6 хувь гэж төсөөлжээ. Жилийн инфляцийг 2021 онд Монголбанк 7.6 хувь, АХБ 6.9 хувьд хүрнэ гэж тооцоолжээ, үүнд эрэлт нийлүүлэлтийн шинжтэй үнийн өсөлт ийнхүү инфляц өсөхөд нөлөөлж, улмаар 2022 онд ч инфляцийн дарамт үргэлжлэх төлөвтэй байна.

Бидний (MeARC) тооцооллоор эдийн засгийн өсөлт энэ онд 4.6 хувь, ирэх онд 5 хувь, харин инфляци энэ онд 6 хувь, ирэх онд 7 хувь байна гэж төсөөлж байна. Энэхүү тооцооллыг эдийн засгийн үзүүлэлтийг шинэчилж өсөлтийг дахин тооцоолох замаар хийгдсэн өсөлтийн төсөөлөл юм (График 13).

График 13. Эдийн засгийн өсөлт, инфляцийн төсөөлөл (MeARC)



2021 оны сүүл хагасаас уул уурхайн бус салбарууд идэвхжих төлөвтэй ба Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх бодлогын хүрээнд арга хэмжээний эерэг нөлөөлөл нь төсөөллийг нэмэгдүүлэхэд хүргэлээ. Харин уул уурхайн салбарын өсөлт уудаашрах хандлагатай байгаа нь эдийн засгийн өсөлтийг бууруулах нөлөө үзүүлэв. 2022 онд дархлаажуулалтын эерэг нөлөөгөөр Ковид-19 цар тахлын эрсдэл буурч, улмаар хил гаалийн хорио, хязгаарлалтууд суларч нийлүүлэлтийн сүлжээний доголдол арилж,

дотоодын эрэлт нэмэгдэх зэрэг эерэг хүлээлтэд үндэслэн эдийн засгийн өсөлтийг өөдрөгөөр харж байна. Харин 2023 оноос гадаад орчин тогтворжиж улмаар дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлт саарч, бусад салбарын өсөлт удаашрах хандлагатай байна.

Макро эдийн засгийн төсөөллийн нөлөө дүгнэлт:

- 2022 онын дунд үеэс эхлэн цар тахлын нөхцөл байдлаас хэвийн амьдралд аажмаар шилжиж энэ нь жижиг, дунд бизнес эрхлэгчдэд эерэгээр нөлөөлөх хандлагатай байна.
- Засгийн газрын хөнгөлөлттэй зээл үргэлжлэх нь ЖДБЭ-дийн санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлж байгаа боловч тэдэнд тулгарах санхүүжилтийн асуудлууд хэвээр байвал уг зээлд хамрагдах боломж хязгаарлагдмал хэвээр байх эрсдэлтэй.
- Инфляци өссөн, нийлүүлэлтийн сүлжээний доголдол үүссэн нь ЖДБЭ-дийн зардлыг цаашид өсгөхөөр байна.
- Дэлхий улс орнууд бодлогын хүүгээ нэмээд эхэлсэн бөгөөд, мөн инфляци, бодит ханш чангарч байгаа зэрэг нь бодлогын хүүг нэмэх нөхцөлийг бүрдүүлж байгаа бөгөөд санхүүжилтийн зардал цаашид өндөр байх төлөвтэй байна.
- Богино хугацаанд төгрөгийн ханш сулрах хандлагатай байгаа бөгөөд энэ нь худалдааны салбарын ЖДБЭ-дад сөргөөр нөлөөлөхөөр харагдаж байна. Худалдааны салбарт бизнес эрхэлдэг ЖДБЭ-дийн тоо маш их байдаг нь энэ салбарт ойрын ирээдүйд төгрөгийн ханшийн уналт сөргөөр нөлөөлөх магадлалтай.

ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖҮҮД

1. Монгол Улс дахь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд өөрийн хөрөнгө нь гарааны санхүүжилтийн үндсэн эх үүсвэр (62%) болж байна. Мөн 5 бизнес эрхлэгч тутмын 1 нь банк болон ББСБ, ХЗХ-ноос зээл авсан бол 14% нь гэр бүл, эцэг эхийн хөрөнгөнд суурилжээ. Харамсалтай нь олон улсын төслийн зээл, “Жижиг, дунд үйлдвэрлэлийн сан”, гадаадын хөрөнгө оруулалт энэ салбарт маш хангалтгүй байна.
2. Сүүлийн 18 сарын туршид буюу цар тахлын нөлөө улсын эдийн засагт сөргөөр мэдрэгдэж эхэлснээс хойш нийт ЖДБЭ-дийн 76%-ийнх нь борлуулалтын орлого буурчээ. Харин энэ хугацаанд 8%-ийнх нь орлого өссөн бол 16% нь өөрчлөлтгүй байна. Өөрөөр хэлбэл 4 компани тутмын 3 нь цар тахалд “өртөж” байна. Мөн 2 компани тутмын 1 нь 2020 онд алдагдалтай ажилласан бол 3 компани тутмын 1 нь л ашигтай ажиллажээ.
3. Сүүлийн 18 сарын туршид нийт ЖДБЭ-дийн 25% нь шинээр санхүүжилт авч чадсан бол 23% нь хүссэн ч эс авч чаджээ. Шинээр босгосон санхүүжилтийн 75% нь банкны зээл бол өөрийн хөрөнгө болон ЖДҮ сангийн санхүүжилт 10%-г тус тус эзэлж байна.
4. Судалгаанд хамрагдсан 4 компани тутмын 1 нь барьцаа хөрөнгө дутмагаас болж зээл авч чадаагүй бол 18% нь зээлийн хүү өндөр байдаг гэж хариулсан. Мөн 17% нь хөрөнгийн үнэлгээ бодитой бус, 12% нь санхүүгийн байгууллагуудын зээлийн процесс удаан, чирэгдэл ихтэй гэж хариулсан бол 10% нь өөрийн тогтмол орлогоо баталгаажуулж чаддаггүй ажээ. Иймд бодлого боловсруулагчдын зүгээс зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг бодитоор дэмжих, зээлийн хүүг шат дараатай бууруулах шаардлагатай байхаас гадна хөрөнгийн үнэлгээний чадавхийг дээшлүүлэх, бодитоор үнэлэх ажлыг эрчимжүүлэх нь чухал болжээ.
5. Нийт судалгаанд хамрагдагсдын 52% нь цар тахлын үед тулгамдаж буй санхүүгийн хамгийн том хүндрэл бол ажилчдын цалин, НДШ гэж хариулсан бол 48% нь НӨАТ, ААНОАТ, Гаалийн болон татварын зардал гэж үзэж байна. Сонирхолтой нь зээлийн төлбөрийн дарамт нийт судалгаанд хамрагдсан ЖДБЭ-дийн 30%-д үүссэн бол цахилгаан, ус, дулаан зэрэг тогтмол зардлууд 10 бизнес эрхлэгч тутмын 4-т нь дарамт болсоор байна.
6. Санхүүгийн бус хүндрэлүүдийн хувьд ЖДБЭ-дийн бараг 70% нь цар тахал, хөл хорионы улмаас үйлдвэрлэл, үйлчилгээ болон хүргэлт тасалдсан нь хамгийн том хүндрэл гэж дүгнэсэн. Мөн 10 компани тутмын 6 нь борлуулалт буурсан, 4 нь түүхий эд, материалын нийлүүлэлт доголдсон гэж үзэж байна. Мөн 16% нь бэлэн мөнгөний хомсдолд өртжээ. Засгийн газраас жижиг, дунд бизнесийн салбарыг дэмжихээр 2020 онд хэрэгжүүлсэн 7 багц арга хэмжээнээс жижиг, дунд бизнес эрхлэгчдэд ердөө 2 шийдвэр нь буюу “тогтмол зардлын төлбөрөөс чөлөөлсөн”, “НДШ-ийг 6 сараар чөлөөлсөн” нь зохих эерэг үр дүнг авчирсан бөгөөд харамсалтай нь бусад 5 арга хэмжээ дорвитой үр дүнд хүрсэнгүй.
7. Монгол Улсын Засгийн газраас тус салбарыг дэмжихээр яг одоо хэрэгжүүлж буй 9 арга хэмжээнээс зөвхөн 1 арга хэмжээ буюу “Тогтмол зардлын төлбөр чөлөөлсөн” шийдвэр ЖДБЭ-дийн 59%-ийн дэмжлэгийг авч чадаж байна. Мөн НДШ-ийн тодорхой хувийг чөлөөлсөн арга хэмжээ бизнес эрхлэгчдийн 30%-д хүрчээ. Харамсалтай нь бусад 7 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрч чадаагүй, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулсан,

тунхаглалын шинжтэй болжээ. Учир нь судалгаанд оролцогчдын дунджаар 75% нь уг 7 арга хэмжээг “нөлөө үзүүлээгүй” гэж дүгнэж буй бол 20% нь “мэдэхгүй” гэж хариулжээ.

8. Тус салбарын 4 компани тутмын 3 нь сүүлийн үед дангаараа эсхүл бусадтай хамтран судалгаа, хөгжүүлэлтийн ажил хийгээгүй гэж хариулсан байна. Эсрэгээрээ 14% нь бүтээгдэхүүн, үйлчилгээний судалгаа, хөгжүүлэлтийн ажил хийжээ. Дүгнэж үзвэл хэдийгээр цар тахлын нөлөө ЖДБЭ-дэд хүчтэй цохилт болж буй нь тодорхой ч манай ЖДБЭ-дийн “антпренер” сэтгэлгээ, чадавхи хангалттай биш байна.

9. Судалгаагаар бүтээгдэхүүн, үйлчилгээний судалгаа, хөгжүүлэлтийн ажилд хөрөнгө зарцуулах нь шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх чадавхийг энэ чиглэлд хөрөнгө зарцуулдаггүй компаниудтай харьцуулахад бараг 4 дахин, шаардлага байхгүй гэж үзсэн компаниудтай харьцуулахад 5 дахин нэмэгдүүлдэг нь батлагдав.

10. Бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлэхэд дотоодын нөөц, түүхий эдийг 100% ашигладаг хэмээн 5 компани тутмын 1 нь хариулсан бол 10 компани тутмын 6 нь орцынхоо ердөө 50 хүртэлх хувийг дотоодын түүхий эд, нөөцөөр хангадаг байна. Өөрөөр хэлбэл цаашид цар тахал болон аливаа улс төр, эдийн засгийн шалтгаанаар хил хаагдах нөхцөлд нийт жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 80%-д нь үйл ажиллагааны доголдол үүсч түүний 75% нь богино хугацаанд түүхий эд, орцын гачигдалд өртөх эрсдэлтэй байна.

11. Гадаадын хөрөнгө оруулалт үйл ажиллагаанд нь нөлөөлдөг эсэхэд мэдэхгүй гэж хариулсан ЖДБЭ-д маш өндөр буюу 42% байгааг анхаарч үзэх нь чухал. Цаашид гадаадын хөрөнгө оруулалтын үр шимийн талаар энэ салбарт сурталчлан таниулах, түүнийг төрийн бодлогоор дэмжих, тогтвортой байдлыг нь хангаж өгөх нь төрийн хувьд чухал сорилт болжээ гэж үзэж байна.

12. Судалгаанд оролцсон нийт ЖДБЭ-дийн ердөө 4% хувь буюу 58 компани бүтээгдэхүүн, үйлчилгээгээ экспортлодог ажээ. Эдгээр компаниудын бараг 20% нь цар тахал, 17.8% нь худалдан авагч орны импортын татвар өндөр, 10.8% нь хил гаалийн ажилтнуудын хүнд суртал, 9.6% нь экспортлогчдод төрийн дэмжлэг сул байдаг нь тус салбарын хамгийн том бэрхшээлүүд гэж үзсэн.

13. Сүүлийн саруудад даамжран үргэлжилж буй Замын-Үүд, Алтанбулаг боомтууд дээр үүсээд буй ачаа, тээврийн саатал, түүнийг дагасан хүнд суртал, өртөг зардлын өсөлт судалгаанд оролцсон нийт бизнес эрхлэгчдийн 71.4%-д “муу” болон “маш муугаар” нөлөөлж байна. Харин нөлөөлөөгүй гэж нийт оролцогчдын 23.6% нь хариулсан. Иймд манай улсын хувьд хилийн боомтуудын хорио цээрийн дэглэмийн стандартыг боомтын ачаалал, багтаамж, ажиллах чадвартай нь уялдуулан дорвитой шинэчлэх шаарлагатай болсныг харуулж байна.

14. Орон нутгийн замын сүлжээ Алтайн бүсийн аймгуудад (Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор) хамгийн хүндрэлтэй буюу тус аймгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 67% нь зам харгүй дэд бүтцийн хамгийн том бэрхшээл гэж үзэж байна. Хангайн бүсийн 52%, зүүн бүсийн 51%, говийн бүсийн 47% нь орон нутгийн зам дэд бүтцийн бэрхшээл үүсгэж байна гэж хариулсан.

15. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувьд бүтээгдэхүүнээ борлуулахад үүсч буй хамгийн том бэрхшээл нь коронавирусын тархалтын улмаас тавьсан хөл хорио болж байна (83.9%). Үүний дараа судалгаанд оролцогчдын 34.4% нь орон нутгийн худалдан

авах чадвар сул, 13.8% нь дотоодын тээврийн сүлжээ хөгжөөгүй, 12.8% нь стандартын агуулах, зоорь хангалтгүй, 12.3% нь худалдан авагч тал монополь шинжтэй гэж хариулсан бол 5.9% нь нийлүүлэлтийн шаталсан (гинжин) бүтэц муу хөгжсөн гэж үзжээ.

16. Жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт “Хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх” арга хэмжээг нийт оролцогчдын 45.2% нь дэмжсэн байна. Энэ төрлийн санхүүжилтэд зөвхөн дотоодын бус гадны ялангуяа нэг талт түнш улс болон байгууллага, олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагуудаас олгодог төрөл бүрийн хөнгөлөлттэй санхүүжилтийн бүх эх үүсвэрүүд багтана.

17. “Татварын таатай орчин бүрдүүлэх” нь энэ салбарт төрөөс үзүүлэх маш чухал дэмжлэг болохыг судалгаанд оролцогчдын 42.7% нь батлав. Иймд ЖДБ-ийн салбарт татварын төрөл бүрийн хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшуулал олгож бизнесийн эко орчныг дэмжих шаардлагатай байна. Мөн бодлого боловсруулагчдын зүгээс “төрийн үйлчилгээний хүнд суртлыг арилгах” арга хэмжээ авах нь энэ салбарыг урт хугацаанд, тогтвортой дэмжих удаах бодлогын арга хэмжээ болж байна.

18. Мөн “авилгалыг арилгах” арга хэмжээ нь жижиг, дунд бизнесийн салбарт чухал нөлөөтэй болох нь судалгаанд оролцогчдын 25.3% нь дэмжсэнээс харагдаж байна. Цаашилбал уг салбарын үйл ажиллагааг зохицуулж буй “хууль, эрх зүйн орчныг сайжруулах”, бизнес эрхлэгчдэд илүү таатай болгох нь манай улсын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварт тун сайнаар нөлөөлөх нь гарцаагүй байна.

19. Цар тахлын үед эмэгтэй захиралтай жижиг, дунд бизнес эрхлэгчид эрэгтэй захиралтай ижил түвшний компаниудаасаа илүү сайн ажиллаж байна. Хямралын үед ЖДҮ салбарын дундаж Монгол эмэгтэй захирал дундаж эрэгтэй захирлаас илүү үр дүнтэй удирдлага, зохион байгуулалт хийж оновчтой шийдвэрүүд гаргаж байна гэсэн дүгнэлт хийгдэв.

20. Засгийн газраас “цар тахлын үед эдийн засгаа сэргээх” бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд байгаа онохгүй байна. Жишээ нь ипотекийн 6%-ийн зээл барилгын болон боловсруулах үйлдвэрлэлийн салбар дахь 293 компанийн ердөө 10 компанид тодорхой хэмжээгээр эерэг нөлөө үзүүлсэн. Мөн хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй зээлийн төрөл бүрийн дэд хөтөлбөрүүд, төсвийн дэмжлэгийн талаар ХАА-н компаниудын 86.3 хувь нь эдгээр хөтөлбөр “нөлөөгүй” эсхүл “мэдэхгүй” гэж хариулжээ.

21. Судалгаанд оролцсон нийт аж ахуйн нэгжүүдийн 91.3% нь буюу 10 компани тутмын 9 нь энэхүү судалгааг ирэх жилүүдэд авбал дахин оролцох хүсэлтээ илэрхийлсэн бөгөөд ердөө 3.9% нь оролцох хүсэлгүй байгаагаа илэрхийлсэн. Өөрөөр хэлбэл судалгааны дэмжих түвшин (approval rate) 90%-иас дээш, эсэргүүцэх бүлэг (denial rate) 4%-иас доош гарсан нь уг судалгааны ач холбогдол өндөр байсныг илтгэж байна.

--ooOoo--

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Bekeris, R. (2012). *The impact of macroeconomic indicators upon sme's profitability*. Ekonomika.

IMF. (2021). *World Economic Outlook*. Washington, DC.

Monitor, G. E. (2020/2021). *Global report*.

Worldbank. (2018). *Global Economic Prospects: The Turning of the Tide?* . Washington DC: Worldbank.

Дэлхийнбанк. (2021). *Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа*. Улаанбаатар, Монгол.

Дэлхийнбанк. (2021). *Монгол Улсын эдийн засгийн тойм: Тусламж дэмжлэгээс сэргэлт өөд*. Вашингтон ДС: Дэлхийн банк.

Монголбанк. (2021). *Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл*. Улаанбаатар.

СангийнЯам. (2021). *Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөл*. Улаанбаатар.